

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 23-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 – 63

I.	<i>Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.03.31-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/</i>	10 – 63
-----------	---	---------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 04 дүгээр сарын 23-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 47 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: Э.Болормаа, Д.Ганбат, Н.Наранбаатар;
Чөлөөтэй: Н.Алтаншагай, Д.Цогтбаатар, С.Эрдэнэболд;*

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Ч.Анар нар хэлэлцэх асуудлын дараалалд орсон Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийн зөвшилцөх асуудлыг хойшлуулах гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 2
Бүгд: 17
88.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн хэлэлцэх асуудлын дараалалд орсон Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцэх асуудлыг хойшлуулах гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 2
Бүгд: 17
88.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.03.31-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн

сайд Ж.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газрын Худалдааны бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Баттуяа, Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газрын Худалдааны бодлогын хэлтсийн зөвлөх Э.Нямбаяр, Гадаад харилцааны яамны Олон улсын худалдаа, эдийн засгийн газрын захирал Г.Өлзийсайхан, мөн яамны Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Соёлмаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нар танилцуулав.

Төсөл санаачлагчийн илтгэл болон Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Ч.Анар, Л.Энхнасан, Ө.Шижир, Х.Тэмүүжин, Э.Бат-Амгалан, Б.Жаргалан, Г.Хосбаяр, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Болорчулуун, Гадаад харилцааны яамны Олон улсын худалдаа, эдийн засгийн газрын захирал Г.Өлзийсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар, Х.Тэмүүжин, Г.Тэмүүлэн нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгох нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 9

Бүгд: 19

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 16 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 18 минут үргэлжилж, 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 23-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
13 цаг 47 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны ирц бүрдсэн байна.

Та бүхэнд өнөөдрийн хуралдаанд ирсэн гишүүдийн ирцийг танилцуулъя. Очирбатын Амгаланбаатар гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн, Батын Батбаатар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Жадамбын Энхбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн, Арвижихын Эрдэнэбүрэн нарын гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц 60.0 хувьтайгаар бүрдсэн байна.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны гишүүддээ хэлэлцэх асуудлаа танилцуулъя.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар даргын зөвлөл дээрээс хэлэлцэх асуудлыг баталсан байгаа. 3 асуудал байсан.

Нэгдүгээрт, Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төсөл.

Засгийн газар 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр ирүүлсэн. Зөвшилцөх асуудал байгаа.

Хоёр дахь асуудал нь, Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл.

Мөн Засгийн газар 04 сарын 04-ний өдөр ирүүлсэн. Зөвшилцөх асуудал байгаа.

Гуравдугаарт нь, Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбоотой гэсэн ийм гурван асуудал байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүд байна уу? Засгийн газрын гишүүн бөгөөд Ц.Туваан сайд хэлэлцэх асуудалтай холбоотойгоор горимын санал гаргаж байна. Ч.Анар гишүүн. 2 гишүүн байна. 2 гишүүнээр тасаллаа. Ц.Туваан гишүүн.

Ц.Туваан: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хурлаар хэлэлцэх асуудалд орсон Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэлэлцүүлэгтэй холбоотой.

Энэ асуудалтай холбоотой хэлэлцүүлгийн шатад Эдийн засгийн байнгын хороо, мөн Төсвийн байнгын хороогоор хэлэлцэгдсэн. Мөн хоёр намын бүлгүүд дээр ярилцаж танилцуулагдсан асуудал байгаа.

Хэлэлцэгдэж байх шатад Байнгын хорооны гишүүд болон Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс энэ хэлэлцээрийг сайжруулах тодорхой зүйл, заалтуудыг өөрчилж шинээр оруулах гэсэн ийм асуудлыг тавьсан.

Энэ асуудал бүгдээрээ хэлсэн гишүүдийнхээ нэр устайгаа, протоколтойгоо байж байгаа. Тодорхой хэлэх юм бол энэ арбитрай холбоотой асуудал. Дээрээс нь Чингис хаан цогцолбор уу, түлшээр хангах цэнэглэх цогцолбор уу. Дээрээс нь 20 жил хүртэлх гээд иймэрхүү 4-өөс 5 асуудал дээр нэлээн гишүүд их давхцалтайгаар санал гаргасан.

Үүнийг хоёр намын бүлэг авч үзээд бүлгүүдийн шийдвэр гарсан.

Ямар шийдвэр вэ гэхээр энэ асуудлыг эргэж хэлэлцээрт нэмж сайжруулах талын асуудлуудыг оруулж ирээч ээ. Тэгж байж дараа нь үргэлжлүүлэн хэлэлцүүлье гэдэг асуудал ярьсан.

Өмнө нь ч гэсэн бид Гашуунсухайт-Ганцмодны хил холболтын Засгийн газар хоорондын хэлэлцээр дээр хэлэлцүүлгийн шатад Байнгын хороодтой зөвшилцөх үед гаргасан гишүүдийн саналыг бас авч үзээд нөгөө талтайгаа ярилцаад сайжруулаад явж байсан шиг энэ жишгээр бид бүхэн дахиж Оросын талтайгаа хэлэлцээрээ үргэлжлүүлж хийе.

Гишүүдийн гаргасан саналын дагуу сайжруулъя гэдэг байдлаар оруулж ирэхээр төлөвлөж байна.

Ийм учраас өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлаас хасаад, тэгээд тодорхой өөрчлөлтүүдийг оруулж ирсэний дараа ахин

хэлэлцэх гэдэг байдлаар шийдвэрлэж өгөөч ээ гэж Байнгын хорооны даргаас болон гишүүдээс хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Ц.Туваан гишүүн горимын санал гаргаж байна. Ч.Анар гишүүн.

Ч.Анар: Ц.Туваан сайдын гаргасан горимын санал дээр санал нэг байна.

Яагаад гэвэл энэ хэлэлцэх асуудлыг буцаан татах шаардлагатай гэж үзэж байна. Ямар үндэслэлтэй юм бэ гэхээр үндэслэлийн хувьд аливаа нэг хүн улсын компани хоорондын болон олон улсын хамтын ажиллагааны хэлэлцээр харилцан ашигтай байх ёстой.

Гэтэл энэ хэлэлцээрийн орж ирж байгаа байдал нь үндсэндээ тулган шаардлагын хэв шинжтэй, зөвхөн Монгол Улсын Засгийн газарт үүрэг хүлээлгэсэн, нөгөө талаасаа танилцуулга дээр заасан шиг

- “тогтвортой байдал”,
- “хямд үнээр хангана”

гэсэн боловч тэдгээр нь зүйл, заалтаар заагдаж өгөөгүй буюу **“ижил тэгш эрхтэй байна”** гэдэг хамгийн том үндсэн хэлэлцээрийн зарчим байхгүй байна гэж үзэж байна.

Хоёрдугаарт, олон улсын гэрээний хувьд байж болох ч гэсэн дотоодын өнөөгийн хуулиудыг давсан, хуулиудаас дээгүүр гарсан өргөн цар хүрээний хуулийн зохицуулалтуудыг шаардлагаар оруулж ирсэн байна.

Мөн цаашдаа Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд гарч мөрдөгдөх газрын тосны бүтээгдэхүүний болон тариф, гаалийн холбогдолтой ирээдүйд зохицуулалтаар хийгдэх хуулиудыг “хамаарахгүй” гэсэн заалт оруулж ирсэн байгаа нь Монгол Улсын хууль тогтоомжид хэр нийцэж байгаа юм бэ гэдэг эргэлзээг үүсгэж байна.

Нөгөө талаасаа гэрээний одоогийн орж ирсэн заалт дээр нэг зүйлийг зайлшгүй анхаарах ёстой.

Гэрээний одоогийн орж ирсэн төслийн 1 дүгээр заалт дээр “агаарын хөлгийн түлш нийлүүлэх болон 4 дүгээр зүйл, заалтад заагдсан үйл ажиллагааг эрхлэхэд” гэдэг үүргийг хүлээж байгаа.

Тэр 4 дүгээр зүйлийн 4.5 дээр байгаа заалт нь “агаарын түлшнээс бусад газрын тосны бүтээгдэхүүний үйл ажиллагааг эрхлэхэд Монгол Улсын Газрын тосны тухай хуулийн 7.2-т зааснаас бусад үйл ажиллагааг эрхлэх, хориглох заалтууд хүчин төгөлдөр үйлчлэхгүй байх” гэсэн заалт орж ирж байгаа юм.

Тэгэхээр энэ гэрээний хэлэлцээр нь өөрөө ганц агаарын хөлгийн түлш нийлүүлэх биш, дотоодын зах зээлийн жижиглэнгийн болон бөөний худалдааны түлш, дизель нийлүүлэх зохицуулалтыг оруулж ирэх боломжийг нээсэн байна гэж үзэж байгаа тул хэлэлцээрт орохдоо анхаарал хандуулахыг хүсэж байна.

Мөн ойлгомжгүй байгаа зүйл. Үүнийг хардах үндэслэлийг үндэслэлтэй болгож байгаа шалтгаан нь Оросын талын итгэмжлэгдсэн төлөөлөгч буюу “Роснефть” компанид тусгай зөвшөөрлүүдийг саадгүйгээр олгох. “Эрдэс Ойл”-оосоо гадна.

Тийм нөхцөлүүдийг бүрдүүлж өгөхийг шаардсан гэх мэтчилэн маш олон зүйл, заалтууд байгаа нь өөрөө энэ ганц агаарын түлшнээс гадна “дотоодын жижиглэн болон бөөний бусад түлшний салбарын хамаарлыг нэмэх боломжийг олгосон хэлэлцээр байна” гэж үзэж байна.

Г.Тэмүүлэн: Та горимын саналаа. Минут нэмж өгье. Ч.Анар гишүүнд.

Ч.Анар: Тэгэхээр олон улсын нөхцөл байдал хүндрэлтэй. Бид агаарын түлшээ гарцаагүй байдлаар нэг улсаас аваад тогтвортой, хямд үнэтэй байх зайлшгүй шаардлага байгаа тул Ц.Туваан сайдын гаргасан горимын саналыг дэмжиж, энэ хэлэлцээрийг дахин боловсруулж оруулж ирэх. Оруулж ирэхдээ хэлэлцээрийг “харилцан ашигтай байлгах”, “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэх”, бодит байдал ямар байгаа боловч гэрээн дээр үзэл баримтлалыг зөрчихгүйгээр нийцүүлж оруулж ирэх, ойлгомжгүй маш олон заалтууд байгаа. Тэрийг нарийвчлан тодорхойлох гэсэн шаардлагын дагуу оруулж ирэхийг хүсэж, горимын саналыг дэмжиж байна.

Г.Тэмүүлэн: Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор хоёр гишүүн горимын санал гаргалаа. Хоёулаа нэг асуудал дээр гаргаж байна.

Асуудлаа оруулж ирж танилцуулах гэж байгаа Засгийн газрын гишүүн буюу Уул уурхайн сайд Ц.Туваан сайд Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хойшлуулъя гэсэн горимын саналыг гаргаж байна.

Ингээд энэ асуудал дээр манай Байнгын хорооны гишүүн Ч.Анар мөн адил хойшлуулах горимын саналыг гаргаж байна.

Тэгэхээр хоёр гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг явуулна.

Ингээд хойшлуулах эсэх асуудлыг шийдвэрлэх байгаа. Ер нь Ц.Туваан сайдын хувьд ч гэсэн сая хэлж байгаа үндэслэл дээрээ үндсэндээ бусад Байнгын хороодын хэлэлцүүлгийн явц бусад гарсан, гишүүдээс гаргасан санал шүүмжүүдийг Засгийн газрын зүгээс анхаарч үзэж, буцаад Оросыг Холбооны Улстай, нөгөө талтайгаа эргэж энэ асуудлыг ярилцъя. Сайтар тохиролцох

асуудлууд байна гэдэг үндсэн зарчмын хүрээнд хойшлуулах горимын саналыг гаргаж байна.

Тэгэхээр үг үсэг, найруулгын хувьд ч, орчуулгын хувьд ч гэсэн анхаарах асуудлууд байх шиг байна. Гишүүдийн гаргаж байгаа дөрөв, таван гол асуудлууд байна.

Саяын таны хэлсэн урт хугацааны гэрээ болон олон улсын нисэх буудлын ашиглалт, удирдлага, менежменттэй холбоотой гэдэг асуудлууд байна.

Дээрээс нь бас нэг хөндөгдөөд байгаа асуудал. Монголд баригдаж байгаа газрын тосны үйлдвэрийн онгоцны түлшийг хэрхэх гэдэг асуудал чинь эргэлзээтэй болох ч гэдэг юм уу. Иймэрхүү олон асуудлуудыг та хэд эргэж харж ярьж үзэх нь зөв байх.

Тэгээд таны ч саналыг хүндэтгэж үзэж байна. Ч.Анар гишүүний ч гэсэн гишүүдээс гаргаж байгаа асуудлууд, саналууд, шүүмжүүд дээр бид хүндэтгэлтэй хандах ёстой. Нөгөө талдаа Монгол Улс парламентын засаглалтай улс. Гишүүдийн гаргасан саналууд дээр Засгийн газар анхаарч ажиллах нь зүйтэй байх гэсэн саналтай байна.

Ингээд гишүүдийн гаргасан горимын саналаар санал хураалтыг явуулъя.

Хоёр дахь асуудал буюу Монгол Улсад агаарын түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлыг хойшлуулъя гэдэг горимын саналаар санал хураалтыг явуулъя. Дэмжье гэдгээр. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. /алх цохив/

Санал хураалтад нийт 17 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжсэн байна.

Ингээд 88.2 хувиар хоёр дахь асуудал буюу Монгол Улсад агаарын түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газрын хоорондын хэлэлцээрийн төслийг хойшлуулахыг дэмжлээ.

Гурав дахь асуудал байгаа. Байнгын хорооны тогтоолын төсөл гээд. Энэ бас нэг жоохон техникийн алдаа гарсан байна. Манай Байнгын хорооноос санаачилж байгаа тогтоолын төслийг уг нь дараагийн долоо хоногт орж ирэхээр байсныг техникийн алдаа гараад энд орж ирсэн байна.

Тэгэхээр нэгэнтээ бичигдсэн учраас үүнийг хойшлуулъя гэсэн саналаар. Байнгын хорооны тогтоолын төслийг хойшлуулъя гэдгээр санал хураалтыг явуулъя.

Миний бие гаргаж байгаа шүү. Байнгын хорооны даргын хувьд.

Гурав дахь асуудлыг хойшлуулъя. Байнгын хорооны тогтоолын төсөл гэсэн зүйл байгаа юм. Энэ дараагийн долоо хоногуудаас орж ирэхээр байгаа. Дэмжье гэдгээр санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 17 гишүүн оролцож, 94.1 хувиар дэмжигдлээ.

Ингээд гурав дахь асуудал хойшиллоо.

Одоо үндсэндээ хэлэлцэх асуудал дээр Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төсөл.

Үүнийг зөвшилцөх асуудлыг хэлэлцэхээр болж байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэг.Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төсөл
/Засгийн газар 2025.03.31-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр сайд танилцуулна.

Л.Гантөмөр сайдыг микрофонд урьж байна.

Ажлын хэсгийг оруулаарай.

Л.Гантөмөр: Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүд Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Манай улс 2024 онд нийт 162 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 27.4 тэрбум ам.долларт хүрч түүхэн дээд амжилт үзүүлсэн.

Үүнээс экспорт нь 15.8 тэрбум ам.долларт импорт, 11.6 тэрбум ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 4.2 тэрбум ам.долларын ашигтай гарсан.

Манай улсын нийт экспортын орлогын 93 хувийг уурхайн бүтээгдэхүүн дангаараа бүрдүүлж, эдийн засгийн төрөлжилт сул байгаа нь манай улсын эдийн засгийн хамгийн эмзэг цэг болж байгаа.

Эдийн засгийн төрөлжилтийг бий болгох, уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл, төрөлжилтийг нэмэгдүүлж, экспортын зах зээлийг тэлж, худалдааг хөнгөвчлөх чиглэлээр бодит ажлуудыг хийх хэрэгцээ шаардлага маш өндөр байна.

Түүнчлэн нийт экспортын 91.2 хувь, үүнээс уул уурхайн бүтээгдэхүүний 94.7 хувийг, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний 82.7 хувийг зөвхөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсад экспортолж байгаа нь гадаад худалдааны хамаарал хэтэрхий нэг туйлт байгааг, эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй түвшинд хүрснийг илтгэж байна.

Өөрөөр хэлбэл нэг улс болон цөөн нэр төрлийн бүтээгдэхүүнээс хамааралтай байгаа эдийн засгийн бүтцийг өөрчилж, олон худалдан авагчид, өргөн хүрээний бараа нийлүүлэх тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлага бий болоод байгаа юм.

Тиймээс гол түнш орнуудтай хийх худалдааны тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулж, өөрсдийн харьцангуй давуу талтай бүтээгдэхүүнүүдээ саадгүй экспортлох. Мөн дотоодын үйлдвэрлэлд шаардлагатай импортын орц, түүхий эд, техник хэрэгслийг хямд үнээр оруулж ирэх замаар үйлдвэрлэлийн зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх чөлөөт худалдааны хэлэлцээрийг шинээр байгуулах шаардлага үүссэн.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо түүний гишүүн орнууд хооронд худалдааны түр хэлэлцээр байгуулах тухай албан ёсны яриа хэлэлцээг 2023 оны 9 дүгээр сараас эхлүүлж, өнгөрсөн хугацаанд талууд нийт 2 удаагийн зөвлөлдөх уулзалт, 3 шатны хэлэлцээг зохион байгуулаад байна.

Мөн тус хэлэлцээрийг байгуулах асуудал болон хэлэлцээрийн явцыг нийт 6 удаа Засгийн газрын хуралдаанд танилцуулсан байна.

Гадаад худалдаа эрхлэгч, бизнес эрхлэгч, үйлдвэр эрхлэгчдийн дунд 4 удаагийн нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан байна.

Тус хэлэлцээрийг хийх ажлын хэсгийг анх Эдийн засаг, хөгжлийн дэд сайд ахлан хариуцаж байсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 44 дүгээр тэмдэглэлийн дагуу тус хэлэлцээрийг хийх ажлын хэсгийг шинэчлэн байгуулах үүргийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад даалгасан.

Засгийн газрын шийдвэрийн дагуу хэлэлцээр хийх ажлын хэсгийг 2025 оны 01 дүгээр сард шинэчлэн зохион байгуулсан.

Тус ажлын хэсэг нь хоёр хэсгээс бүрдэх бөгөөд хэлэлцээрийн төслийн бичвэрийг эцэслэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ахалж байгаа.

Гишүүдийн бүрэлдэхүүнд холбогдох яамдын газрын дарга нарыг оролцуулан байгуулсан.

Харин барааны жагсаалтад санал, зөвлөмж боловсруулах чиг үүрэг бүхий дэд ажлын хэсгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ахалж, салбарын мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, холбогдох яамдын оролцоо бүхий 25 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Барааны жагсаалтад санал боловсруулах дэд ажлын хэсгээс 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр нийт 23 барааг тус хэлэлцээрийн Монголын тарифын үүрэг амлалтын жагсаалтаас асуулгах саналыг ирүүлсэн.

Энэ хүрээнд нийт 3 удаа албан бичгээр санал солилцож, 1 удаа биечлэн хэлэлцээр хийсэн.

Үүний үр дүнд талууд хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцсон бөгөөд Монгол Улсын талаас импортын нөлөөлөлд эмзэг тодорхой бараануудад айлын талаас буулт хийлгэж, харилцан ашигтай тохиролцоонд хүрсэн гэж бид үзэж байгаа.

Хэлэлцээрийн хүрээнд хоёр талаас ижил тооны буюу бараа тодорхойлох кодчлолын уялдуулсан системийн 6 оронтой кодоор 367 нэр төрлийн бараанд

- ▶ тарифыг шууд тэглэх,
- ▶ тариф бууруулах,
- ▶ тохирсон квотын хэмжээнд тарифыг тэглэх,
- ▶ тохирсон квотын хэмжээнд тарифын хөнгөлөлт эдлэх

гэсэн үндсэн 4 төрлөөр тарифын саад тотгорыг бууруулахаар тохиролцлоо.

Манай улсын стратегийн болон хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний импортын нөлөөллийг бага байлгахад онцгойлон анхаарсан бөгөөд тоон хэмжээний хязгаарлалт тогтоох, зарим барааг хасуулах замаар дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зохицуулалтыг чадах чинээгээрээ хэлэлцээрийн төсөлд тусгалаа.

Тухайлбал, өндөгний хувьд манай улсын сүүлийн 3 жилийн дотоодын хэрэглээ жилд дунджаар 448.6 сая ширхэг байсан бөгөөд үүнээс 165 сая ширхэг буюу 36.8 хувийг импортоор нийлүүлсэн байна.

Дотоодын өндөгний үйлдвэрлэлийн зах зээлийг хамгаалах зорилгоор өндөгний зах зээлийн 20 хувийг импортын орон зайд үлдээж, 90 сая ширхэг хүртэлх импортын өндөгт гаалийн татварыг 50 хувь бууруулж, 7.5 хувь байхаар тохиролцсон.

Харин 90 сая ширхгээс илүү өндөг импортлогдсон тохиолдолд гаалийн татвар 15 хувь хэвээр байхаар тохиролцлоо.

Харин улаан буудайн хувьд манай улс жил бүр ургац хураалтын нөхцөл байдал, гурилын үйлдвэрлэлийн технологийн шаардлагаас шалтгаалж 30-аас 50 мянган тонн улаан буудайг импортлох шаардлага үүсдэг бөгөөд айлын талаас хатуу болон зөөлөн улаан буудайд нийтэд нь 180 мянган тоннын квот санал болгосон.

Үүнийг 50 мянган тонн хүртэл хэмжээнд одоогийн татварын хэмжээг 1.25 нэгж хувиар бууруулж, 3.75 хувийн татвар ногдуулах бөгөөд 50 мянган тонноос дээш импортлогдсон хэмжээнд 5 хувийн татвар хэвээр хадгалагдахаар тохиролцсон.

Энэ квотыг Монгол Улсын Засгийн газар тогтооно гэдэг ийм хэлэлцээр хийгдсэн байгаа.

Олон улсад чөлөөт худалдааны хэлэлцээр хийхэд түгээмэл ашиглагддаг ерөнхий тэнцвэрийн загварыг ашиглан тооцоолол хийж үзэхэд манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 0.02 хувь, хөрөнгө орууруулалт 2.75 хувь нэмэгдэх ийм үр дүн харагдаж байгаа.

Тухайлбал, Евразийн эдийн засгийн холбооны зах зээлд нийлүүлэх

- мах, махан бүтээгдэхүүний экспорт 125-аас 140 хувь,
- хувцас 84 хувь,
- ноос, ноолуур 64 хувь,
- нэхмэл, сүлжмэл хувцас 55 хувь,
- арьс, ширэн эдлэл 46 хувь тус тус нэмэгдэх боломж байна.

Эдгээр зах зээлд Монголын бараа, бүтээгдэхүүн ийнхүү гаалийн татваргүй нэвтэрч чадсанаар зах зээлд эзлэх байр суурь, өрсөлдөх чадвараа цаашид нэмэгдүүлэх өргөн боломж бүрдэнэ.

Үүнийг тодотговол Евразийн эдийн засгийн холбооны улсуудын нийт хэрэглээ бус зөвхөн импортын хэмжээнд гэхэд 2023 оны байдлаар

- мах, махан бүтээгдэхүүн 706 сая ам.доллар,
- арьс, ширэн бүтээгдэхүүн 6.9 тэрбум ам.доллар,
- ноос, ноолуурын эдлэл 7.5 тэрбум ам.долларын импорт хийсэн байна.

Монгол Улсад хэрэгжүүлж байгаа

“Цагаан алт”, “Хүнсний хувьсгал”, “Шинэ хоршоо” зэрэг хөтөлбөрүүдээр дамжуулан хөдөө аж ахуй мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээнүүд идэвхтэй хэрэгжиж байгааг дурдъя.

Өнөөдөр хэлэлцэж байгаа энэхүү хэлэлцээр нь дээр дурдсан төрөөс хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдээр бий болох суурь тогтолцоог бүрэн утгаар нь цааш хөгжүүлж, дотооддоо боловсруулах, экспортлох, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалт, бизнесийн орлогыг нэмэгдүүлэх юм.

Улмаар хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэ цэн нэмэгдэж, Монголын 250 мянган малчин өрхийн хаалгаар бодитой орлого, ашиг олж очно.

Энэхүү худалдааны түр хэлэлцээрийг байгуулснаар аж ахуйн нэгжүүдийн экспортын зардал буурахаас гадна худалдааны үйл ажиллагаа илүү нээлттэй болж, гадаад худалдаа эрхлэгчдэд нийтлэг тулгамддаг асуудлуудыг хөнгөвчилж хялбаршуулна.

Хэлэлцээрт туссан худалдааг хөнгөвчлөх онцлох зохицуулалтуудаас дурдъя.

Зайлшгүй ашиглагддаг боловч дотооддоо бэлтгэн нийлүүлж чадахгүй байгаа гадаад улсын гаралтай орц, материалыг экспортлох, барааны өртгийн 50 хүртэл хувьд тооцуулах боломж бүрдүүлснээр илүү хялбар экспортлох бараандаа тарифын чөлөөлөлт авах боломж бүрдэнэ.

Гаалийн байгууллагууд 4 цагийн дотор худалдаа эрхлэгчдэд барааг олгож, худалдаа эрхлэгчдэд тулгардаг бодит саад бэрхшээл буурна.

Барааны гарал үүслийн гэрчилгээг хатуу шаардахгүйгээр 12 сарын дотор нөхөн гаргаж, тарифын хөнгөлөлт эдлэх боломж бүрдэх юм.

Бүх бараанд тавьдаг гаалийн шалгалтыг багасгаж, эрсдэлийн менежментийг хэрэгжүүлнэ.

5 мянган еврогоос бага үнэтэй бараанд гарал үүслийн гэрчилгээ шаардахгүй болж, жижиг дунд бизнес, цахим худалдаа эрхлэгчдэд хялбар экспортын боломж бүрдүүлнэ.

Хэрэв Монгол талын дотоод процедураар тус хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгогдсон тохиолдолд 2025 оны 06 сарын 26-наас 27-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Беларусь Улсын Минск хотноо Евразийн эдийн засгийн холбооны дээд зөвлөлийн уулзалтын үеэр хэлэлцээрт гарын үсэг зурах боломжтой талаар Евразийн эдийн засгийн холбооны комиссоос мэдэгдсэн байгаа.

Иймд Монгол Улсын олон улсын гэрээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу хэлэлцээрийг Улсын Их Хурлын Байнгын хороотой зөвшилцөн шийдвэрлэх тул тус асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа Засгийн газрын албан тушаалтнууд, ажлын хэсгийнхнийг танилцуулъя.

Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газрын Худалдааны бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Баттуяа, Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газрын Худалдааны бодлогын хэлтсийн зөвлөх Э.Нямбаяр, Гадаад харилцааны яамны Олон улсын худалдаа, эдийн Засгийн газрын захирал Г.Өлзийсайхан, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Соёлмаа, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн.

Сангийн яам байна уу? Сангийн яамыг дуудъя.

Хууль зүй Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын дарга Ч.Нарантуяа.

Хууль зүйн яам байна уу? Нэрсүүдээ өгөөд өөрсдөө ирээгүй байна. Энэ холбох албан тушаалтнуудыг дуудаарай.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ч.Болорчулуун.

Хөдөө аж ахуйн яамныхан бас алга байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Монгол Улсын Монгол Үндэсний Худалдаа, Аж

Үйлдвэрийн Тамхимын Ерөнхийлөгч Л.Төр-Од, Монгол Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Тамхимын Гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Батсайхан, Монгол Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Тамхимын Гадаад худалдаа, экспортыг дэмжих төвийн ахлах Д.Адьяасүрэн гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байгаа юм байна.

Ирээгүй албан тушаалтнуудыг дуудаарай. Хөдөө аж ахуйн яамных. Д.Довчинсүрэн дарга байна. Тийм ээ. Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яамны газрын дарга нар.

Ингээд хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл танилцуулна.

Н.Батсүмбэрэл гишүүнийг микрофонд урья.

Н.Батсүмбэрэл: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр ирүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа дээрх хэлэлцээрийн төслийн хэлэлцэх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг төслийг хэлэлцэх асуудлаас хойшлуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүд дэмжсэн бөгөөд Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаараа дээрх хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн хүрээнд ижил тооны буюу бараа тодорхойлох кодтой уялдуулсан системийн 6 оронтой кодоор 367 нэр төрлийн бараанд тарифыг шууд тэглэх, тариф бууруулах, тохирсон квотын хэмжээнд тарифыг тэглэх, тохирсон квотын хэмжээнд тарифын хөнгөлөлт эдлэх гэсэн үндсэн 4 төрлөөр тарифын саад тотгорыг бууруулахаар талууд тохиролцсон байна.

Мөн Монгол Улсын стратегийн болон хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний импортын нөлөөллийг бага байлгахад онцгойлон анхаарсан бөгөөд тоон хэмжээний хязгаарлалт тогтоох, зарим барааг хасуулах замаар дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зохицуулалтыг хэлэлцээрийн төсөлд тусгажээ.

Евразийн эдийн засгийн холбооны гишүүн орнуудад экспортлох 621 нэр төрлийн бараанаас 619 төрлийн барааны гаалийн тарифыг тэглэж, цагаан архи,

шар айргийн тарифыг 25 хувиар бууруулах, Монгол Улсын экспортын тэргүүлэх ач холбогдол бүхий бараанууд татваргүй экспорт хийх боломж бүрдэхээр байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед

-Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Монгол Улсын олон улсын гэрээ хэлэлцээр, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрүүдийг судалж үзээд тамхин бүтээгдэхүүнд ногдох гаалийн татвараас чөлөөлөх зохицуулалтаас уг бүтээгдэхүүнийг хасах, хэлэлцээрийг дахин хийх боломжийн талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар хэлэлцээрт нэгдэх нь цаг хугацааны хувьд зөв эсэх талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа Монгол Улс хэлэлцээртэй холбоогүйгээр бизнесийн орчныг таатай болгох, татварыг багасгах, бүртгэл тооцоо, зөвшөөрлийг багасгах, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бизнесийн орчныг сайжруулах талаар ямар алхам хийх талаар,

-Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл хэлэлцээрийн дараа бодит үр дүн хэрхэн гарах талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан энэ хэлэлцээрт орсноор манай улсын төсвийн орлого, гаалийн болон бусад татварууд буурах эсэх, түр хэлэлцээрийн хугацаанд экспортод чиглэсэн үйлдвэрүүд баригдаж амжих эсэх, үйлдвэрүүд байгуулагдсан тохиолдолд бүтээгдэхүүнээ экспортлох боломжтой эсэх, үйлдвэрүүд байгуулагдаж амжихгүй тохиолдолд үүсэх эрсдэлийн талаар судалгаа, шинжилгээ хийсэн эсэх, хэлэлцээрээс сөрөг нөлөө үүссэн тохиолдолд хэлэлцээрээс гарч болох эсэх талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан өмнө байгуулсан бусад хэлэлцээрийнхээ нөхцөлийг сайжруулахад хэрхэн анхаарч байгаа талаар, Евразийн эдийн засгийн холбоотой хэлэлцээр байгуулсан бусад жижиг улс орнуудын туршлага дээр дүн шинжилгээ хийсэн эсэх, төлбөр тооцооны талаар, чөлөөт бүс, аж үйлдвэрийн парк, татварын хөнгөлөлт зэрэг давуу талуудаа бий болгосны дараа хэлэлцээр эхлүүлэх нь зүйтэй талаар,

-Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг манай улсын аж ахуйн нэгж, байгууллагад энэ том зах зээл рүү орох бэлтгэлтэй эсэх талаар, бодит зах зээлийг нээчихвэл давуу байдлыг олж авах хэчнээн аж ахуйн нэгж байгаа талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин хэлэлцээрт нэгдэх нь цаг хугацааны хувьд аж ахуйн нэгжүүд бэлэн байгаа эсэх, махны экспорттой холбогдуулан Евразийн хэлэлцээрт байгаа улсуудаас тавьдаг тарифын бус

хорио цээртэй холбоотойгоор Монгол Улсын талаас хийх ажил болон төлбөр тооцооны талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир хэлэлцээрт ороход Гадаад харилцааны яамны байр суурь, гэрээнд өгсөн саналуудын талаар, Евразийн 5 улс руу өөрсдийн ч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг экспортлох стандартын зөрүү болон энэ чиглэлээр хийгдсэн судалгаа байгаа эсэх, 367 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж ахуйн нэгжийн судалгааны нэгтгэл, төлбөр тооцоог ямар валютаар хийх талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд худалдааны түр гэрээ байгуулах эсэх, Евразийн холбоонд элсэж байгаа эсэх, Европын Холбоо болон Япон Улстай хийсэн өмнөх гэрээнүүдээ сайжирсан эсэх, нийлүүлэлтийн тогтолцоо бэлэн эсэх талаар, үндэсний үйлдвэрлэгч холбоодтой ярилцсан эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар Монголын Топ-100 аж ахуйн нэгжээс илүүтэй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч, экспортуудыг илүүтэй анхаарах. Энэ хэлэлцээр нь Монголын аж ахуйн нэгжүүд ашигтай байх талаар,

-Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл татварын асуудлаас өмнө малын халдварт өвчин, хорио цээр, олон улсын стандартын асуудал цаг хугацааныхаа хүчин зүйлийг шийдвэрлэсний дараа хэлэлцээрийг хийх талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан манай улсад энэ хэлэлцээр ашигтай эсэх, дотоодын үйлдвэрлэгчид үүнээс үр ашиг хүртэж чадах эсэх, монгол хүн ажилтай байж чадах эсэхэд анхаарал хандуулах, хөнгөн хуумгай аргаар шийдвэр гаргахгүйд анхаарч ажиллах, иргэд, аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг маш сайн өгөх талаар,

-Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хэлэлцээрийн талаар дэлгэрэнгүй ярьж ойлгуулах. Үүний ач холбогдол, сөрөг олон давуу тал, үр ашиг хүртэхийн тулд ямар бэлтгэлтэй байх ёстойг хувийн хэвшилд таниулах, үүнд бэлтгэл хугацаа өгөх, гадаад худалдааны хэлэлцээрүүд хийж байгаа энэ цаг үед хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих дэд бүтцийн хөрөнгө оруулалтад төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих багц хуулиуд, эрх зүйн орчныг бүрдүүлэх, улс төрөөс хараат бус байх талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу одоо явагдаж байгаа хэлэлцээр нь 2022 оноос эхлэн үргэлжилж байгаа талаар,

-Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн хэлэлцээрийн үр дүнд хяналт мониторинг тогтмол хийж, хагас жил тутам дүгнэх, бага хүүтэй зээл авдаг өндөр хөгжилтэй орнуудын аж ахуйн нэгжүүдтэй 18, 20 хувийн өндөр хүүтэй зээл авч

байгаа манай дотоодын аж ахуйн нэгжүүд өрсөлдөхөд хүнд байгааг анхаарах, малын гаралтай түүхий эдийн стандартыг хангуулахад анхаарах талаар,

-Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нийтийн эрүүл мэндийг хамгаалах, түүнээс үүдэх эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулах зорилгыг Эдийн засгийн байнгын хороо онцгой анхаарч хэлэлцээр тусган, гаалийн татварыг хасах барааны жагсаалтаас тамхийг хасах талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа бодлогын хувьд Монгол Улсын худалдааны бүх зах зээлийг нээж байж бизнес эрхлэх, хөрөнгө оруулах нөхцөл бүрдэнэ гэсэн саналыг тус тус хэлсэн болно.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийг хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээрээ шийдвэрлэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийг зөвшилцөх тухай Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Х.Тэмүүлэн: Н.Батсүмбэрэл гишүүнд баярлалаа.

Ингээд Эдийн засгийн байнгын хорооноос хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтийг Н.Батсүмбэрэл гишүүн танилцууллаа.

Төсвийн байнгын хорооноос хэлэлцсэн талаарх хэлэлцээрийн төслийн санал, дүгнэлтийг миний бие уншиж танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр хүргүүлсэн байна.

Төсвийн байнгын хороо 2025 оны 04 дүгээр сарын 16, 23-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 75 дугаар зүйлд заасны дагуу дээрх хэлэлцээрийн төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Хэлэлцээрийн төсөлд хөрөнгө оруулалт, худалдаа үйлчилгээ, банк санхүү, төлбөр тооцооны асуудлууд тусгагдаагүй, зөвхөн барааны худалдааны хүрээнд байгуулах бөгөөд Монгол Улсаас гаралтай 621 нэр төрлийн бараа, Евразийн эдийн засгийн холбооны гишүүн орнуудаас гаралтай 499 нэр төрлийн барааны гаалийн тарифын хувь хэмжээг тохиролцсон байна.

Энэхүү хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсаас Евразийн эдийн засгийн холбооны гишүүн орнуудад экспортлох нийт 621 нэр төрлийн бараанаас 619 барааны гаалийн тарифыг тэглэж, цагаан архи, шар айргийн гаалийн тарифыг 25-аар бууруулах, улаан буудай болон өндөгний дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор квот тогтоож, гаалийн тарифыг тэглэхгүй бууруулахаар тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг түр хэлэлцээр нь манай улсын эдийн засагт нөлөөлдөг гол салбаруудын үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай шууд хамааралтай тул болгоомжтой хандах нь зүйтэйг анхааруулж, гаргасан тооцоо судалгааны талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл энэхүү худалдааны түр хэлэлцээрийг байгуулах эсэх нь үндэсний үйлдвэрлэл эрхлэгчид болон тухайн салбарт ажиллагсдын анхааралд байгаа тул хэлэлцээрийн талаар олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан эсэх. Мөн зарим судалгааны дүнгүүд зөрүүтэй байгааг тодруулж асуусан бол,

-Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал манай улс худалдааны түр хэлэлцээрт ороход стандартыг хангасан 367 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн бэлэн эсэх талаар асууж, “Хүнсний хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд 19 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилт тавиад тодорхой хөрөнгө хүч зарцуулж байгаа энэ үед түр хэлэлцээрт орж зарим бүтээгдэхүүний тарифыг тэглэж байгаа нь баялаг бүтээгчдийнхээ хүч хөдөлмөрийг үнэгүйдүүлэх эрсдэлтэйг анхааруулсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг хэлэлцээрийг байгуулахдаа нийтийн эрүүл мэндийн үр нөлөөг харах нь зүйтэй бөгөөд Монгол Улс 2003 онд батлагдсан Тамхины хяналтын суурь конвенцид нэгдсэн тул энэхүү конвенцод тусгагдсан олон улсын чөлөөт худалдааны гэрээ хийхдээ тамхи, тамхин бүтээгдэхүүнийг гаалийн албан татвараас чөлөөлөх, хөрөнгө оруулалтыг дэмждэг байдлыг зохих заалтыг үндэслэн барааны жагсаалтаас тамхи, тамхин бүтээгдэхүүнийг хасах нь зүйтэй гэсэн саналыг хэлж энэ талаар баримталж байгаа бодлогын талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг түр хэлэлцээрийг байгуулснаар эрх ашиг нь хөндөгдөж байгаа аж ахуйн нэгж, тухайн салбарын үйлдвэрлэл эрхлэгчидтэй зөвшилцөх нь зүйтэй талаар санал хэлж, Оросын Холбооны Улс

руу нийлүүлэх экспортын барааны нэр төрөл, борлуулалтын талаар болон хэлэлцээрийг байгуулснаар манай улсын экспорт тэдэн хувиар нэмэгдэх талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут хэлэлцээр харилцан ашигтай байх хүрээнд манай улсын эдийн засагт үзүүлэх үр ашиг болон хэлэлцээрээр зөвхөн гаалийн тарифыг тэглээд, бусад татварууд хөнгөлөлт эдлэх эсэх болон гэрээнд тусгасан бараанууд тарифын бус шаардлагыг хангах эсэх талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах үүднээс үндэсний үйлдвэрлэгчдийн дунд хэлэлцээр байгуулахтай холбоотой хэлэлцүүлгийг зохион байгуулан саналыг авах нь зүйтэй талаар санал хэлж, түр хэлэлцээрийг байгуулах нь малчдын бодит орлогод хэрхэн нөлөөлөх талаар асуулт асуулаа.

-Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа өмнө байгуулагдсан гэрээ, хэлэлцээрийн үр дүнд үндэслэн дараагийн томоохон үйлдвэрлэгч орнуудтай гэрээ байгуулах асуудлыг шийдвэрлэж байх нь зүйтэй гэсэн саналыг хэлж, хэлэлцээрийг байгуулснаар бүтээгдэхүүнээ экспортод гаргахад үндэсний үйлдвэрлэгчид хэрхэн бэлтгэлтэй байгаа талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаяр хэлэлцээрт нэгдсэнээр зах зээл тэлэх боломжтой тул хэлэлцээрийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, хэлэлцээрийг байгуулснаар нефтийн гаралтай бүтээгдэхүүний үнэ болон төмөр замын үйлчилгээний үнэ буурах эсэх талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням шинээр тохирсон хэлэлцээрийн нөхцөлийг мэргэжлийн байгууллагуудаар судлуулсан эсэх болон Европын улсууд, Япон Улстай байгуулсан чөлөөт худалдааны хэлэлцээрийн үр дүнг Улсын Их Хуралд танилцуулах боломжтой эсэх талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир хэлэлцээрийн Монгол Улсын эдийн засагт нөлөөлөх үр ашиг болон хэлэлцээрийн төслийг үндэсний үйлдвэрлэл эрхлэгч нараар хэлэлцүүлсэн үр дүнгийн талаар асуулт асууж, хариулт авсан байна.

-Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг, Ж.Батжаргал нар хэлэлцээрийн талаарх тооцоо судалгааг холбогдох байгууллагуудаар гаргуулах, мөн дотоодын үйлдвэрлэгчдээр хэлэлцүүлсний дараа хэлэлцэх нь зүйтэй гэж,

-Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хорооноос хамтарсан ажлын хэсэг байгуулж, хэлэлцээрийн төслийг хэлэлцүүлэх шаардлагатай талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн гишүүдийн тооцоо судалгаа дутуу байна гэдэгтэй санал нэг байгаагаа илэрхийлээд, хэлээд хэлэлцээрт орсноор эдийн засгийн боломж, бодит ашиг, үр дүнг тооцсон тодорхой асуудлыг хэлэлцүүлэх нь зүйтэй гэж,

-Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн энэхүү хэлэлцээр Монгол Улсын эдийн засаг, иргэдийн амьдрал ахуйтай шууд холбоотой бөгөөд асуудлыг нягталж, гишүүдийн хэлсэн үг болон мэдээллийг нэгтгэх шаардлагатай тул хэлэлцүүлгийг түр хойшлуулах нь зүйтэй гэсэн талаар санал хэлсэн байна.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийг Төсвийн байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар үргэлжлүүлэн хэлэлцээд, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Байнгын хорооны гишүүд ээ,

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүнийг гишүүн орны хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн гэсэн байна.

Ингээд хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Г.Хосбаяр гишүүнээр тасаллаа. О.Номинчимэг гишүүн асуулт асууна.

О.Номинчимэг: Би асуулт гэхээсээ илүү үг, санал хэлэх гэсэн юм.

Ер нь олон хэлэлцүүлэг дээр байр сууриа илэрхийлж байгаа. Хэлэлцүүлэг ч болж байна. Ер нь энэ хэлэлцээрийг харахаар Евроазийн хэлэлцээр гэдэг маань талхнаас хямдхан тамхи импортлох хэлэлцээр л болоод байна. Ингэж л харагдаж байна.

Тэгээд бид талхтай адилхан үнэтэй байгаа тамхиа гаалийн 30 хувийн татварыг нь тэглэнэ гэдэг энэ хэлэлцээрээр орж ирж байна. Үр хүүхдэдээ үхлийн хор бэлддэг төр байж болохгүй шүү дээ. Төрийн түшээдээ.

Энэ агуулгаараа энэ хэлэлцээр батлагдах юм бол бид хорт хавдраа дийлэхээ болино. Одоо тамхи, тамхин бүтээгдэхүүн, залуучуудын дунд бол энэ VAPE тамхи гээд зөндөө их тархчихсан байгаа.

Одоогийн нөхцөл байдлаа яая гэж байж* хорт хавдраа дийлэхгүй байж, одоо энд хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлс болох энэ тамхин дээрээ гаалийн 30 хувийн татварыг нь байхгүй болгоно гээд орж ирж байгаа чинь хорт хавдрын өмнө Монголын төр цагаан тугаа өргөж бууж өгч байгаа байдлаар л түүхэнд энэ үлдэнэ шүү. Энэ хэвээрээ батлагдах юм бол.

Тамхинаас болж цаг бусын байдлаар 4300 хүн жилдээ нас барж байна.

Ер нь олон улсад ч гэсэн судалгаа байгаа. Тамхины татвар багасах юм бол, тамхины татварт танагдахад оршуулгын газар тэлдэг гээд. Энэ бол хатуу үг. Үүнийг бүгдээрээ ойлгож, нийтийн эрүүл мэндийн асуудлаа, хүний аюулгүй байдлаа хамгаалах ёстой.

Мөн одоо яг миний хоёр хажуу талд сууж байгаа хоёр сайддаа хэлмээр байна. Сайд нар аа, хэлж байгаа үгэндээ хариуцлагатай бай.

Энэ асуудлыг хэлэхээр онцгой албан татвараараа бид нөхчихнө өө, онцгой албан татвараа нэмчихнэ гэж байгаа. Энэ бол шулуухан хэлэхэд улс төрчдийн зохиосон аргаа ядсан үлгэр шүү.

Онцгой албан татвар яагаад тамхи, архи гэсэн энэ бүтээгдэхүүнүүд дээр тавигддаг юм. Энэ өөрөө татвараар бид хэрэглээг багасгах гэсэн зорилготой. Анхны хамгийн гол зорилго нь төсөв бүрдүүлэх биш. Энэ татвараар хэрэглээг багасгах зорилготой. Ийм ч учраас улс орнууд архи, тамхи дээрээ онцгой албан татвар буюу SIN TAX гэдэг. Тийм ээ. “Нүглийн татвар” гэдэг юмыг хийдэг юм.

Үүнийг бага байлгах нь эрүүл мэндээ, хүүхдүүдээ, залуучуудаа хорлож байгаа учраас “нүглийн татвар” гэж тавьдаг юм.

Гаалийн албан татвараар төсөв бүрдүүлдэг. Энэ хэлэлцээрээр чинь тамхин бүтээгдэхүүний гаалийн 30 хувийг нь албан татварыг байхгүй болгох юм бол төсөв бүрдүүлж байгаа 68 тэрбум төгрөг чинь байхгүй болно.

Энэ 68 тэрбум төгрөгөөр жилд хэдэн сургууль, цэцэрлэг барих юм, хэдэн хавдрын эмчилгээнд зарцуулж болох юм, хэдэн сайн багш нарыг цалинжуулж болох юм. Эдийн засаг, хөгжлийн яам үүнийхээ тооцоог хийгээрэй.

Онцгой албан татварыг нэмээд нэмээд энэ асуудал шийдэгдэхгүй. Нэгэнт одоо бид энэ улсаас орж ирж байгаа тамхин дээр бид 200 хувь, энэ улсаас орж ирж байгаа тамхин дээр нь 100 хувийн онцгой албан татвар тавина гэдэг бодлогыг хэрэгжүүлж чадахгүй. Энэ бол татварын нэгдсэн онцгой албан татварын бодлого биш. Бүгд дээр нь адилхан тавьдаг.

Ингэхээр гарааны тэгш бус байдлаас эхэлж байгаа тамхин бүтээгдэхүүний хувьд зах зээл дээр юу болох вэ гэхээр нэг хэсэг нь үнэтэй

болоод, конторбанд руу шилжинэ. Нэг хэсэг нь хэт хямдаараа байгаад дахиад хүүхдийн эрүүл мэнд, залуучуудын асуудал, нөгөө бид нарын хамгийн гол зорилго болгож байгаа эрүүл мэндээ хамгаалъя, нийтийн эрүүл мэндээ хамгаалъя, үүнээс гарч байгаа эдийн засгийн зардлаа багасгая гэдэг зорилт чинь хэрэгжихгүй. Үүн дээрээ анхаараач ээ төрийн түшээд ээ.

Тэгэхээр өнөөдөр ингээд энэ хэлэлцээр зөвшилцөхөөр одоо эцсийн хэлэлцүүлэг энд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр болж байна.

Би энд байгаа гишүүдээ уриалмаар байна. Энд сууж байгаа төрийн түшээддээ, хэлэлцээр хийж байгаа энэ хүмүүстээ бас уриалмаар байна. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос зөвшилцсөн бичиг хэрвээ гарах тохиолдолд зайлшгүй энэ хэлэлцээрийг дахин хэлэлцэж, тамхийг гаалийн татвараас чөлөөлөх энэ бүтээгдэхүүний листээс хасах чиглэлийг өгмөөр байна.

Ингэж байж бид ирээдүй хойч үеэ хамгаалсан шийдвэр гаргаж чадна. Энэ дээр манай Байнгын хорооны гишүүд анхаараад өгөөч ээ гэдгийг хүсмээр байна.

Г.Тэмүүлэн: О.Номинчимэг гишүүн үг хэллээ. Санал хэллээ. Ч.Анар гишүүн асуулт асууя.

Ч.Анар: Ж.Энхбаяр сайдаас хоёр асуулт, Эдийн засаг, хөгжлийн яамны сайд Л.Гантөмөр сайдаас нэг асуулт асууя.

Бид гаалийн татварыг одоо тэглэх хэлэлцээр нийт өргөн нийтийн барааны бүтээгдэхүүн дээр, 360 бүтээгдэхүүн дээр яриад байдаг. Гэтэл одоо эргээгээд гурилын татвар тэглэсэн асуудлаа эргээгээд нөхөн сэргээх энэ хэлэлцүүлэг яваад байдаг. Тэгээд энэ хоёр чинь зөрчилдөөд байгаа юм биш үү? Тэгээд энэ алдаан дээрээсээ ухамсарлаад дотоодын үйлдвэрлэлээ хамгаалаад, дэмжээд, хүнсний аюулгүй байдал гээд олон хүнсний аюулгүй байдлыг хангах урт хугацааны мөрийн хөтөлбөрүүдээ хэрэгжүүлсэн.

Гэтэл нөгөө талдаа эсрэгээр нь бүр илүү өргөн цар хүрээтэй эрсдэлд орж байгаа юм биш үү? Энэ дээрээ та нэг тайлбар хэлж өгөөч? Би бол логикийн зөрчилдөөнтэй байна гэж хараад байна.

Хоёрдугаарт, Ж.Энхбаяр сайдаас дахиад асуухад. Та одоо үүнийг хариуцаж байгаа хүн. Засгийн газрын дэргэдэх Аюулгүй байдал судалгааны хүрээлэнгийн дүгнэлт нийтлэгдсэн байна лээ. Түүн дээр Евразийн эдийн засгийн худалдааны хэлэлцээр дээрх Киргиз, Армен Улсууд оролцоод, яг бид нарын өнөөдрийн ярьж байгаа шиг дотоодын зах зээл дээр боломж нээгдэнэ. Бид одоо ингээд 200 сая хэрэглэгчтэй зах зээл рүү, 5 улсын зах зээл рүү гарна гэсэн боловч Киргиз бол төсвийн орлогын гаалийн татварын орлого байхгүй болсон.

Армен бол дотоодын үндэсний үйлдвэрлэл нь сүйрсэн. Тэгээд ер нь дотоодын зах зээл нь бүхэлдээ Орос, Казахстан, Беларусын бүтээгдэхүүнээр дүүрсэн нөхцөл байдалтай. Маш том алдаа болсон. Энэ үндэслэлийг харж үзээд Тажикстан, Узбекистан энэ хэлэлцээрт нэгдэхээс татгалзаж байгаа гэсэн дүгнэлт байна.

Тэгэхээр энэ судалгааныхаа дүгнэлтийг Засгийн газар авч хэлэлцдэг юм уу? Бид өөрсдөө ингээд таамаглаад яриад байна. Энэ хоёр асуултыг Ж.Энхбаяр сайдаас.

Л.Гантөмөр сайдаас асуух юм нь, магадгүй одоо бид 90 онд маш олон татварын таатай бүсээс хамаарч оёдлын үйлдвэрийн цехүүд нээгдэж байсан. Түүн шиг магадгүй одоо Япон, Солонгосын компаниуд, Хятадын компаниуд нь энэ Евроазийн зах зээл рүү Монголоор дамжиж гарах гарц, магадгүй Америк руу ч гарах гарц байж болох юм гэсэн судалгаа тооцоо хийгдсэн үү? Эдийн засгийн тооцоолол хийгдсэн үү? Тийм судалгаанууд байгаа юу? Ашигтай гарах хувилбарыг тооцож үзсэн юм уу?

Тэгэхээр үнэхээр тийм ашигтай гарах хувилбар байгаа бол тэрийгээ та танилцуулаач ээ гэж хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Ч.Анар гишүүний асуултад хариулъя. Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Гурил энэ хэлэлцээрт ороогүй буюу Евразийн холбоо Монголын гурилын босго 15 хувийн татварыг хүлээн зөвшөөрсөн гэсэн үг.

Харин бид үүндээ нийцүүлээд татвараа маргааш хэлэлцээд шийдвэл бид дотоодынхоо газар тариалан болон энэ үйлдвэрлэлээ хамгаалах бололцоо бүрдэнэ. Нэг.

Хоёрдугаарт, Монгол Улсыг Киргизтэй харьцуулж болохгүй. Дээрээс нь Аюулгүй байдал, судалгааны хүрээлэн Засгийн газрын судалгааны хүрээлэн биш.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэдэх Стратеги судалгааны хүрээлэн гэж албан ёсны байгууллага бий. Энэ бол Аюулгүй байдал, судлалын хүрээлэн бол өөр. Сайн дурын, төрийн бус байгууллагын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хүрээлэн шүү.

Ямар боломж. Эрсдэл талаасаа. Бид боломжоо төрүүлж харна.

Бидний Евроазид хийх давуу тал бид нарт байгаа мал. Хамгийн их олон мал байна. Үүн дээр тулгуурласан мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн байна.

Ялангуяа манай уламжлалт арьс шир, ноос, ноолуур, хүйтэн сэрүүн бүсийн 200 гаруй хүн амтай зах зээл дээр манай хөнгөн үйлдвэрлэлийн салбар гарах таатай нөхцөл бүрдэнэ.

Эд бүгд 5-аас 50 хувийн татварын хязгаарлалттай байсан. Үүнийг аваад хаяхад манай хөнгөн үйлдвэрийн салбар энэ сэрүүн бүсийн орон зай дээр маш амжилттай өрсөлдөх бололцоотой.

Нөгөө талаар хүнсний бүтээгдэхүүн. Хүнс дээр импорт нэмэгдэнэ. Нэр төрөл эрс олширно. Хэрэглээн дээр олон төрлийн барааны сонголт бий болно.

Нийт хүнсний 94 бараа энэ хэлэлцээрт импорт талдаа Монгол Улсад орж ирнэ. Үүний эсрэг бид “Хүнсний хувьсгал”, “Атрын-IV” гээд бодлогын хүрээнд хамгаалалт хийж байгаа 19 нэр төрлийн бараагаа хамгаалах зохицуулалтуудыг хийж байгаа. Гол гол нэр төрлийн бараан дээр хэлцэл үндсэндээ хийгдсэн.

Ингээд зарим саналаа тавиад бид хасуулсан. Зарим дээр нь харилцан буулт хийж тохирсон. Йогурт, жигнэмэг, өрмөнцөр, эрдэст ус гэсэн бүтээгдэхүүнийг бид хасуулж чадаагүй буюу үндсэндээ бид гол зорилтод хамгаалах бараандаа хамгаалалт хийсэн.

Нөгөө талаар энэ хэлэлцээрт онцгой албан татвар болон нэмүү өртгийн албан татвар энэ хэлэлцээрт ороогүй. Бидэнд онцгой албан татвараараа зохион байгуулж зохицуулах, дотоод үйлдвэрлэлээ хамгаалах арга хэрэгсэл байна гэсэн үг. Саяын дурдсан тамхи дээр гэхэд орон оронд нь зориулсан, бүс бүсэд нь зориулсан бид онцгой албан татвараа Их Хурал батлаад явахад энэ дотоод өрсөлдөөн тэгш байдлыг хангаад явах бололцоотой.

Дахиад нэг зүйл хэлэхэд, одоо бид ер нь яг энэ цаг үед л энэ бүс рүү гарч өрсөлдөх хэрэгтэй. Нөгөө талдаа гадаад улс төрийн нөхцөл байдалтай холбоотойгоор Европын Холбоо, бусад орнуудтай эдийн засгийн хоригтой үед бидэнд өрсөлдөхөд харьцангуй давуу тал орж ирнэ. Үүнийг ашиглаж бид өнгөрсөн 30 жил бий болсон энэ чадавхаа нэг сориод үзмээр байгаа юм. Энэ Их хурал энэ гэрээний үр дүнг авч үзнэ. Бид 2028 оны 5 сард энэ гэрээгээ дүгнэнэ.

Үнэхээр ахиц дэвшил гараад, Монголын үйлдвэрлэлээ бэхжүүлээд, экспортын олон тулгуурт эдийн засгийг бий болгох энэ гол зорилтоо хангаж чадвал маш сайн ололт болно.

Энэ дээр үнэхээр сул дутуу боллоо гэвэл үүнийг үргэлжлүүлэхгүй байх бололцоо байгаа. Энэ бол түр гэрээ гэдгийг сайн ойлгоно. Холбоонд орж байгаа, элсэж байгаа асуудал байхгүй. Үүрэг хүлээж байгаа зүйл байхгүй. Хамгийн гол нь бид нарын алсын хараа.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Ж.Энхбаяр сайдад нэмж 1 минут өгье.

Ж.Энхбаяр: Монгол Улсыг хөгжүүлэх “Алсын хараа-2050”-д бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэж худалдааг хөнгөвчлөх зорилт тавьсан.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортын хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна гэсэн зорилт байдаг.

Нэг орноос худалдан авах бараа, бүтээгдэхүүний нийт импорт хэт давамгайлахаас сэргийлэх бодлогыг баримтална гэж байгаа. Үнэхээр энэ дээр худалдааны тэнцвэрт байдал алдагдсан байгаа. Нэг орноос хэт хамааралтай байгаа. Үүнийг цөөлөхөд Евроазийн манай хүйтэн бүсийн, манай уламжлалт гол хөнгөн үйлдвэрийн зах зээлд нэлээн эерэг өөрчлөлт гарна. Бүгдээрэ нэг оролдоод үзье, өрсөлдөөд үзье. Бидэнд давуу талууд их бий шүү.

Бид үндэснийхээ үйлдвэрт итгэх хэрэгтэй. Дагасан бусад ирэх онуудын төсөвт бид татварын болон бусад бодлогын дэмжлэгүүдийг, тарифын бус бусад дэмжлэгүүдийг, банк, санхүүгийн хөшүүргүүдийг бид бас эндээ дайчилж ашиглах ёстой.

Г.Тэмүүлэн: Л.Гантөмөр сайд нэмж хариулъя.

Л.Гантөмөр: Ч.Анар гишүүний асуултад хариулъя.

Логикийн алдаа ерөөсөө байхгүй. Бид одоо жишээлбэл гурилан дээр гарч байгаа сургамж юу вэ гэвэл 5 хувийн татварын үнэ цэнийг одоо бид ойлгож байгаа.

Тэгэхээр бид Оросын Холбооны Улс руу гаргах гэж байгаа манайд үйлдвэрлэж чаддаг 367 төрлийн бараан дээр 10-аас 40 хувийн тариф тавьсан байдаг. 10-аас 40 хувь.

Тэгэхээр энэ өндөр тарифыг бид тэглэх тухай хэлэлцээр гэдгээ цөмөөрөө ухамсарлах хэрэгтэй. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, дахиад логикийн зөрчил алга. Юу вэ гэхээр бид яг гурил шиг өргөн хэрэглээний дотооддоо үйлдвэрлэдэг бараануудынхаа тарифыг хэвээр нь үлдээж байгаа. Зарим нэг дээр нь тодорхой хэмжээний квот өгч байгаа. Өгнө гэдэг нь угаасаа авдаг бараан дээрээ квот үлдээж байгаа.

Тийм учраас бид хүнсний ногоо, газар тариалантай холбоотой бүтээгдэхүүн, дээр нь хөнгөн хүнсний үйлдвэрлэлийг яг босгож ирж байгаа бүтээгдэхүүнүүдээ бүрэн хамгаалсан гэж өнөөдөр ойлгож ажилдаа орж байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ер нь экспортлоход гаднын хөрөнгө оруулалт хэр болов гэдэг асуулт байгаа. Энэ дээр бид энэ гэрээнд орохдоо юуг түлхүү хөндсөн бэ гэвэл манайд үйлдвэрлэгдсэн барааны орц дотор 50 хувь нь гаднын орц найрлага бараа, бүтээгдэхүүн байж болно гэдэг ийм тохиролцоо хийж чадсан.

Энэ юу вэ гэвэл тодорхой хэмжээний гаднын хөрөнгө оруулалт, гаднын тоног төхөөрөмж, гаднын түүхий эд Монголын түүхий эдтэйгээ нийлээд бараа, бүтээгдэхүүн болоод ингээд экспортод гарахдаа Монголын гарал үүслээр тарифынхаа хөнгөлөлтийг эдлэх ийм боломжийг авч чадаж байгаа.

Тийм учраас яг энэ 367 нэр төрлийн бараан дээр гадаад хөрөнгө оруулалт шууд утгаараа нэмэгдэнэ гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Л.Энхнасан гишүүн асуулт асууна.

Л.Энхнасан: Баярлалаа. Энэ Евроазийн хэлэлцээрийн холбоотой талуудын байр суурийг бид зөвлөлийнхөө хурал дээр сонссон. Яах вэ илүүтэй би энэ хэлэлцээртэй холбоотой юмнуудыг асууя гэж бодож байна.

Миний ойлгож байгаагаар хэлэлцээр маань түр хэлэлцээр байгаа.

Тэгэхээр түр хэлэлцээрийн тохиолдолд хэрвээ импортын барааны үнэ буурч, өрсөлдөөн нэмэгдэж, дотоодын жижиг, дунд үйлдвэрлэгчид урьдчилсан таамаглалаас илүүтэй сөрөг нөлөөлөл үүсэх тохиолдолд энэ гэрээнээс яаж гарч болох вэ?

Ер нь гэрээнд яг гарах тэр нөхцөлийг нь оруулсан уу? Тухайлбал, манай улстай адилхан түр гэрээ байгуулсан улсуудыг харахад Иран, Вьетнам, Сербигэрээ байгуулсан байгаа. Иран 3 жилийн хугацаатай хэлэлцээр байгуулаад, тэгээд үргэлжлүүлээд гишүүн орон болсон байгаа.

Тэгэхээр ер нь энэ заалт тусгагдсан юм уу? Хэрвээ түр хэлэлцээрийн явцад ямар нэгэн маргаан үүсэх юм бол аль улсын шүүх, арбитраар хэлэлцэх вэ?

Мөн түр хэлэлцээрийн хүрээнд Евразийн эдийн засгийн нийтлэг стандарт, хяналт, гаалийн шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай болох уу? Хэрвээ мөрдөх шаардлагатай болох юм бол хэчнээн Монголын байгууллагууд энэ шаардлагыг хангаж чадах вэ? Энэ дээр хийсэн тооцоо байна уу? Хэрвээ хангаж чадахгүй бол Монголын экспортыг хязгаарлах болзошгүй болох юм биш үү?

Ер нь энэ хэлэлцээрийг байгуулсан бусад улсуудын жишгийг харж дүгнэсэн үү? Гадаад хэргийн яам энэ дээр ер нь ямар бодол, байр суурьтай байгаа юм бэ? Үүнийг сонсьё.

Г.Тэмүүлэн: Л.Энхнасан гишүүний асуултад хариулъя. Л.Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Л.Энхнасан гишүүний асуултад хариулъя. Түрүүн Ч.Анар гишүүний асуулт дээр нэг зүйл, ийм ойлгомжгүй яриа яваад байгаа юм.

Одоо Армен ч юм уу, Киргизийг манайтай адилтгаж хараад байгаа юм. Үгүй. Бид бол гишүүнээр орохгүй. Гишүүнээр орсон орнуудын тухай дээр гарсан тайлан. Хэрвээ Монгол Улс Евразийн эдийн засгийн холбоонд гишүүн болох юм бол энэ их өргөн хүрээний хэлэлцээр болно. Өргөн хүрээний үйл хэрэгт оролцоно.

Ингээд эхлэх юм бол харин манай эдийн засагт хохиролтой. Бодитойгоор хэлэхэд.

Тийм учраас бид Евразийн холбоонд гишүүнээр элсэхгүй гэж байгаа юм. Евразийн эдийн засгийн холбоонд ажиглагч гишүүнээр ч гэсэн бид орохгүй гэж байгаа юм. Бид маш хязгаарлагдмал хүрээнд Монголын хөдөө аж ахуйн салбарын хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бараа бүтээгдэхүүнийг энэ зах зээл рүү экспортлох хэлэлцээрийг л хийж байгаа. Ердөө 360 хэдэн бүтээгдэхүүн дээр.

Л.Энхнасан гишүүний тухайд, гарах асуудал бол ерөөсөө мэдэгдэл өгөөд л болно. 3 жилийн хугацаатай түр хэлэлцээр. Гаръя гэх юм бол 3 жилийн дараа мэдэгдэл өгөөд жилийн хугацаанд энэ ингээд дуусах байгаа юм.

Энэ дээр ямар нэгэн маргаан мэтгэлцээн явагдах үндэслэл байхгүй. Энэ өөрөө айхтар үүрэг хүлээгээгүй. Аль аль талдаа 367 бараан дээр тарифын хөнгөлөлт өгье гэдэг ийм хэлэлцээр учраас энэ дээр айхтар тийм хамааралд орно гэдэг болгоомжлол энэ удаагийн хэлэлцээр дээр байхгүй юм шүү гишүүд ээ гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Болсон уу? Гадаад хэргийн яам Л.Энхнасан гишүүний асуултад хариулъя. Гадаад хэргийн яамны байр суурь. Хэн хариулах вэ? 3 номер. Дараа нь 7 номер. 3 номер.

Б.Анар: Эдийн засаг, хөгжлийн яам. Ч.Анар. Л.Энхнасан гишүүний асуултад хариулъя.

Хэлэлцээр 3 жилийн хугацаатай. 3 жилийн дараа хэрэгжилтээ харж байгаад сунгаж болно, цуцалж болно. 12 сарын өмнө мэдэгдлээ өгөөд хэлэлцээрийг 3 жилийн дараа дуусгаж болох ийм зохицуулалттай.

Энэ хэлэлцээр өөрөө түр хэлэлцээр. Байнгын хэлэлцээр болгож болно. Түүнээс энэ нь ямар нэгэн байдлаар нөгөө холбооны гишүүн болно гэсэн асуудал бол байхгүй.

Байнгын хэлэлцээр болсон ч ямар нэгэн байдлаар гишүүн орон байхгүй. Хэлэлцээрээ хийгээд явж болдог. Тухайлбал, Серби, Вьетнам гээд улсууд яг ийм байнгын худалдааны хэлэлцээртэй. Таны хэлсэн Иран бас түр хэлэлцээртэй байж байгаад одоо байнгын хэлэлцээр болгоод явсан байгаа.

Хоёр дахь нь, арбитрын журмын талаар асуусан. Олон улсын нөгөө ВІТ^[bilateral investment treaty] загвар дээр хэрэглэдэг талууд өөр өөрсдийнхөө төлөөлөх нэг нэг арбитрчаа сонгоод, хоёр арбитрч нь дундаасаа гуравдагч арбитраа сонгоод явна.

Талууд өөрсдийн одоо нөгөө state to state.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: 3 номер нэмээд микрофон өгье.

Б.Анар: Улс хооронд явж байгаа маргаан яг нөгөө олон улсын ВІТ загвар дээр заасан байдлаараа арбитрчаа сонгоод, зардлаа өөрсдөө хариуцаад явах байдлаар яг нөгөө Дэлхийн худалдааны байгууллагын стандарт загвар дээр туссан байдлаараа туссан байгаа.

Г.Тэмүүлэн: Гадаад харилцааны яам нэмж тайлбар өгье. 7 номер.

Г.Өлзийсайхан: Л.Энхнасан гишүүний асуултад хариулъя. Гадаад яамны Олон улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирал Г.Өлзийсайхан байна.

Манай яамны хувьд 2015 онд энэхүү холбоо үүсгэн байгуулагдсанаас хойш хамтын ажиллагааны механизмтай, хамтарсан зөвлөл хуралддаг.

Энэхүү зөвлөлийн хүрээ 2019 оноос ялангуяа ажиглагч гишүүн болохгүй. Бидний хувьд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг хамтарсан байдлаараа судалж үзье гэдэг ийм судалгааг хоёр тал гаргаад хамтарсан судалгаа хийгээд явсан.

Энэхүү судалгааны дүнд одоо яригдаж байгаа импортын татварын орлого багасах, дээрээс нь экспортын нэмэлтийн асуудал, импортын нэмэгдэл гэсэн энэ асуудлууд гарч ирсэн байдаг.

Энэхүү судалгааны дүнг тухайн үед бид урьдчилан Сайдын зөвлөлийн хурлаараа хэлэлцээд Эдийн засаг, хөгжлийн яам байгуулсны дараа энэхүү хамтарсан судалгааны ажлаас гарсан. Хамтарсан судалгааны ажил дууссаны дараа энэхүү түр хэлэлцээрийн асуудал босож ирсэн байгаа. Энэхүү түр

хэлэлцээрийн асуудалд манай яам хамгийн сүүлийн раундад Москвад болсон 03 сарын 02-нд болсон хуралдаанд оролцсон. Энэхүү хуралдааны дүнгээр л Монгол Улсын стратегийн гэж хэлж болох бүтээгдэхүүнүүдийг хэлэлцээрийн жагсаалтаас хассан ийм асуудал байгаа.

Тэгэхээр бид бүхний хүргүүлж байсан саналууд тусгалаа олсон гэж үзэж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Л.Энхнасан гишүүний микрофоныг өгье. Нэмж тодруулъя.

Л.Энхнасан: Евразид мөрдөж байгаа нийтлэг стандарт, журмыг мөрдөх шаардлагатай болох уу? Энэ дээр та нар хийсэн тооцоолол, гаалийн шаардлагуудыг.

Г.Тэмүүлэн: 3 номер нэмж хариулъя.

Б.Анар: Энэ хэлэлцээр бол яг энэ бүтээгдэхүүнүүдийн ангилалыг тохирсон гаалийн тарифыг тодорхой хумигдмал хүрээнд тарифаа харилцан бууруулах, хөнгөлүүлэх ийм л хэлэлцээр.

Хорио цээрийн хэлэлцээр гэж байдаг. Худалдааны хэлэлцээрүүдийг дагаад байгуулдаг. Үүнийг бүтээгдэхүүн тус бүр дээр, махан бүтээгдэхүүн, үхрийн мах, хонины мах гээд бүгдийг нь тусдаа байгуулах ёстой.

Энэ хэлэлцээрээр ямар давуу байдал үүсэж байгаа юм бэ гэхээр бид дэлхийн худалдааны байгууллагуудад элсээд орсон улсууд хорио цээрийн ерөнхий стандартыг мөрдөнө гээд үүрэг амлалтууд авсан байгаа.

Энэ хэлэлцээр дээр юу гэж заасан бэ гэхээр хоёр улс харилцан нэмэлтээр хорио цээрийн стандартыг өөрөөр тохирч болно, энэ хэлэлцээрийг өөрөөр хийж болно гэсэн үг.

Тэгэхээр Дэлхийн худалдааны байгууллагад зааснаас илүү хөнгөлөлттэй нөхцөлөөр хорио, цээрийн хэлэлцээрээ тохирох ажил хүлээгдэж байгаа. Үүнийг хариуцсан яамдууд ойрын хугацаанд яаралтай хийгээд явах шаардлага, боломж үүснэ. Энэ хэлэлцээрээр.

Г.Тэмүүлэн: Л.Энхнасан гишүүн нэмж тодруулъя.

Л.Энхнасан: Тэгвэл энд стандарт, гааль, ложистик, эрүүл ахуйн асуудлыг шийдвэрлэх байнгын механизм юм уу? Ажлын хэсэг байгуулах заалт тусгагдсан байгаа юу?

Г.Тэмүүлэн: 3 номер асуултад хариулъя.

Б.Анар: Дундын ажлын хэсэг гээд. Энэ Японы хэлэлцээр дээр бүлэг болгон тус тусдаа ажлын хэсэг жишээ нь гараад явсан байдаг.

Энэ компакт хэлэлцээр учраас нэгдсэн нэг том ажлын хэсгээр ямар нэг худалдаатай холбоотой хүндрэл үүсэх юм бол хоёр тал харилцан шууд зөвлөлийн механизмаа ажиллуулаад асуудлыг түргэн шуурхай шийдвэрлээд явуулах байдлаар оруулсан байгаа.

Яг энэ хэрэг хэлэлцээрийг хэрэгжүүлэх дотоод төлөвлөгөө үргэлжлээд гаргахаар манай яамны зүгээс ажиллаж байгаа. Яг энэ хэлэлцээрийн дагуу нэмэлтээр хийгдэх бүх ажлуудыг дэлгэрэнгүй гаргасан. Рариуцах байгууллагуудыг хариуцлагажуулсан ийм төлөвлөгөө хэлэлцээр байгуулагдсаны дараа үргэлжлээд гараад явна гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа.

Г.Тэмүүлэн: Ө.Шижир гишүүн асуулт асууна.

Ө.Шижир: Одоогоос яг 9 жилийн өмнө Японтой чөлөөт худалдааны хэлэлцээр хийж байхад яг манай асуултад хариулж байгаа хүмүүс шиг ийм хариултууд өгч байсан юм байна.

Би нөгөө протоколуудыг бүгдийг нь авч уншсан юм. Япон бол өөрөө дэлхий дээр гурав дахь том зах зээл. Бид нарт ийм том зах зээл нээгдэж байгаа нь монголчуудад бараг одоо олдож байгаа ховор завшаан.

Бид үүнээс хоцорч болохгүй. Нэгэнт Японы ийм өндөр аж үйлдвэржсэн өндөр технологитой ийм улстай хамтын ажиллагааны гэрээ, чөлөөт худалдааны гэрээ байгуулснаар манай компаниудын дэлхийд өрсөлдөх чадвар өсөж, Японд экспортод гаргана. Жилийн дараа Японоос оруулж байгаа хөрөнгө оруулалт 400 сая доллар хүрнэ. Манай бүтээгдэхүүн бүгд Японы зах зээлд гарна гээд. Энэ өөрөө 28 хуудас ийм протокол байна.

Тэгээд эндээс нэг нь ч хэрэгжээгүй. Юу нь хэрэгжсэн бэ гэвэл манай стандарт яг хэвээрээ байгаад, Японы стандартад хүрч чадаагүй буюу манайх экспорт хийж чадаагүй. Эсрэгээрээ Японоос импортолж байгаа хэмжээ нь 1.8 тэрбум доллар болтлоо өссөн. Бид 40 хэдхэн сая долларын экспорт хийдэг хэвээрээ.

Тэгэхээр чөлөөт худалдааны хэлэлцээрийг бид ингэж их сайн харах ёстой юм шиг байна. Сая энэ Гадаад яамнаас сая юу гэсэн бэ? Стратегийн бүтээгдэхүүн болон стратегийн бүтээгдэхүүнийг тарифаас хасуулаад тариф тогтоосон гэсэн үү?

Тэгээд архи, пиво стратегийн бүтээгдэхүүн юм уу? Энэ дээр чинь архи, пиво, дарс гээд бичсэн байна шүү дээ. 25 хүртэл гээд. Би үүнийг ойлгосонгүй.

Тэгээд бид Японы стандартыг хангаж байгаа нэг ч бүтээгдэхүүн байхгүй. Бид энэ чөлөөт худалдааны хэлэлцээрт орсон хэвээрээ л байгаа. Өнөөдрийг хүртэл 9 жилийн өмнө Их Хурлын гишүүдийн ярьсан сайхан юм нэг ч биелээгүй.

76 гишүүнээс 53 нь хуралд ороод 49-өөр баталсан юм байна. 92.5 хувиар.

Тэгээд өнөөдөр энэ нэг нь ч хэрэгжээгүй байгаа. Хэрэгжээгүй шалтгаан нь бид бэлэн биш байсан байхгүй юу. Эхлээд зах зээлээ нээдэггүй юм байна. Эхлээд өөрсдийнхөө үйлдвэрлэлийг бэлэн болгодог юм байна. Тэр стандартыг нь хэвлэж, үйлдвэрлэж чаддаг болгодог юм байна. Тэгж байж бүтээгдэхүүн нийлүүлдэг юм байна л даа.

Тэгээд дахиад нэг жишээ хэлэхэд одоо ганцхан жилийн өмнө монголчууд импортын гурилыг багасгаад бид хямд гурил иднэ гэсэн. Тухайн үеийн ханшнаасаа гурил жишээ нь хамгийн багадаа 152 төгрөгөөр, хамгийн ихдээ 232 төгрөг килограмм тутамдаа өссөн байна. Орос гурил 40-өөс 60 төгрөгөөр килограмм тутамдаа өссөн байна.

Тэгээд бид импортын татваргүй бараа, бүтээгдэхүүн өсөөд байхад чөлөөт худалдааны хэлэлцээрт орохоор энэ бараа, бүтээгдэхүүнүүд өсөхгүй гэдэг баталгаа байгаа юу? Бид үүнийг хүлээн зөвшөөрөх үйлдвэрлэлийн хүчин чадал байгаа юу?

Тэгээд би саяын хоёр асуултдаа эхлээд асуултаа аваад тэгээд тодруулгаа авчихъя.

Г.Тэмүүлэн: Ө.Шижир гишүүний асуултад хариулъя. Л.Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Ө.Шижир гишүүний асуултад хариулъя.

Японтой хийсэн хэлэлцээрийг манайхан их буруу ойлгоод байгаа юм. Японтой ийм чөлөөт худалдааны хэлэлцээр гэж хийгдээгүй. Япон Улстай бид эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хийсэн.

Эдийн засгийн хувьд түншлээ гэж байгаа юм. Түншлэх ажлаа Монгол Улсын Засгийн газар хийж чадахгүй өнөөдөр хүрсэн. Үүнийхээ бурууг жишээлбэл хэлэлцээр лүүгээ чихдэг. Энэ бол их буруу юм тогтох гэж байна.

Япончууд тухайн үед өөрснөө хэлж байсан юм. Үгүй ээ, тэгээд нэг хэлэлцээр хийдэг. Яг түншлэлийн түвшинд хамтарч ажиллаж чадахгүй бол манайхаас орсон жаахан бараан дээр одоо янз бүрийн юм яриад байх вий дээ гэж. Яг одоо энэ гарч ирж байна.

Энэ Япон талаас идэвхжиж байгаа худалдаа бол ерөөсөө машин дээр байгаа. Монголчуудын машин худалдаж авах чадавх л нэмэгдээд байгаа юм.

Зээлээр авдаг. Машинд зарцуулж байгаа мөнгөний хэмжээ нэмэгдсэн гээд. Энэ тоог хамтын ажиллагааны түншлэлийн хэлэлцээр лүүгээ бид бухах маягтайгаар Японы хэлэлцээр лүү айхтар халдаж боломгүй байна.

Энэ хэлэлцээр бол ийм зузаан хэлэлцээр. Үүнийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэ бол Монгол Улсын Гадаад яам Японы Гадаад яам хоёр хамтын ажиллагаагаар хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тийм учраас энэ хэлэлцээрийг ажлын хэсгүүдийг нь тогтмол хуралдуулж Монголчууд асуудлаа тавих ёстой. Зарим барааг нь авахгүй гэж хэлж болно. Зарим дээр нь хөрөнгө оруулалт оруулбал бид авна гэж бас хэлж болно. Хамтын үйлдвэрлэл хийгээд Япон руу, Японы зах зээл рүү бараагаа гаргая гэж хэлж болно. Нэг үгээр хэлбэл хоёр Засгийн газар эдийн засгийн хувьд түншлээд, эдийн засгаа босгож ирэх учиртай хэлэлцээр байхгүй юу.

Одоо энэ хийж байгаа бол өөр. Энэ бол Монголд үйлдвэрлэж байгаа 367 барааг, өөрийнхөө чаддаг барааг энэ зах зээл рүү татваргүйгээр гаргая гэдэг ийм л хэлэлцээр.

Таны болгоомжлол зөв. Яаралтай асуудлаа шийдээч ээ. Бэлтгэн нийлүүлэх тогтолцоогоо хий. Дарханыхаа аж үйлдвэрийн паркийг байгуул. Би бол тэгж л ойлгож байна. Бараа, бүтээгдэхүүнийхээ Эмээлтийнхээ аж үйлдвэрийн паркийг хурдал. Тэр “Цагаан алт” хөтөлбөрөө хурдан хэрэгжүүл. Бараа, бүтээгдэхүүнээ бэлд, гарга гэсэн ийм л санаа гэж би хувьдаа ойлгож байна.

Тэгэхээр өчигдөр тэр О.Цогтгэрэл нэг график үзүүлээд ингээд буруу мэдээлэл Монгол даяар тараагаад байгаа юм.

Тийм учраас одоо цаашдаа хэдүүлээ энэ хэлэлцээр болгоноо салгаж, юу юм бэ, ямар учиртай юм бэ гэдгээ харж жигнэж, бүр шаардлагатай бол тухайн хэлэлцээрийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр Японтой хийсэн эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг энэ цаг үеийн гишүүдэд нэг задлаад харуулмаар байхгүй юу.

Энэ чинь ийм учиртай. Энэ механизм ажиллаж байна. Энэ нь ажиллахгүй байна гээд. Тэгэхгүй бол одоо зүгээр худалдааны гэрээ хийсэн юм шиг бид ингэж буруу ойлгож цаашаа явж болохгүй гэж хэлмээр байна.

Тэгээд бид бэлтгэх цаг наргүй ажиллаж байж нэгдсэн тогтолцоогоо хийж авна. Цаг наргүй ажиллаж байж энэ малчдынхаа түүхий эдийг боловсруулдаг болно. Цаг наргүй ажиллаж байж үүнийг нөгөө зах зээлдээ таниулна. Түрүүн Ж.Энхбаяр сайдын хэлдгээр үнэхээр хүйтэн орчинтой энэ зах зээл дээр л энэ нэг жоохон бараагаа зарж чадахгүй юм бол бид ер нь хэцүү байна шүү гэдэг ийм л зүйл байгаа.

Тийм учраас энэ гэрээг бид чулуу болгохын төлөө явъя гэж би Та бүхнээс хүсэж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Ж.Энхбаяр гишүүн нэмж тайлбар өгье.

Ж.Энхбаяр: Тэгээд л боломжийн талаар сая хөндлөө.

Мах, махан бүтээгдэхүүн Евроазийн дотоодын хэрэглээ нь 706 сая доллар байгаа. Импорт. Бид дөнгөж 5.8-хан сая долларын экспорттой.

Тэгэхээр манайх 50 хувийн татвартай байгаа шүү дээ. Үхрийн мах гэхэд л. Энэ тэглээд ирнэ.

Тэгэхээр бид мал эмнэлэг, энэ биокомбинатынхаа бодлогыг жоохон сайжруулаад л. Энэ 700 сая долларын махны импортын орон зай дээр бид оролцох бололцоотой.

29 төрлийн махан бүтээгдэхүүн орно. Манай.

Арьс, шир дээр 60 нэр төрлийн бараа орно. Татваргүй. 6.9 тэрбум долларын зах зээл байгаа юм. Евразийн холбооны орнуудын импорт. Бид 0.5-хан сая долларын экспорт байгаа. Арьс, шир дээр. 6 тэрбумын орон зай руу л бид өрсөлдөнө өө л гэсэн үг.

Ноос, ноолуур дээр манай 204 төрлийн ноос, ноолууран бүтээгдэхүүн орно. Татваргүй орно. 7.5 тэрбум долларын зах зээл, импорт байна. Бид 6.6 саятай байгаа. Одоо.

Энэ мэтчилэн манай өрсөлдөх, яг одоо бидний хийж байгаа “Цагаан алт” хөтөлбөр маань экспортын болох, уурхайгаас ангид олон тулгуурт эдийн засагтай болох, үүнийгээ дагаад нөгөө хөдөө аж ахуйгаа эрчимжүүлэх, малчдаа хоршоожуулах. Ингээд нөгөө мал эмнэлэг, түүхий эдийн чанараа нэмэгдүүлэх гээд их олон бодлогыг энэ нэг талаасаа. Хөнгөн үйлдвэр дээр үнэхээр их том боломж гарна. Тэгээд бид энэ том зах зээл дээр нэг өрсөлдье гэж хүчээ нэг соримоор байгаа юм.

Бид ер нь энэ 30 жил хэр болсон юм бэ гэж.

Г.Тэмүүлэн: Болсон уу? Ө.Шижир гишүүн. Х.Тэмүүжин гишүүн асуулт асууна.

Х.Тэмүүжин: Надад хоёр, гурван асуулт байсан юм.

Гадаад хэргийн сайд байсан бол Гадаад хэргийн сайдаас асуумаар санагдаад байгаа юм.

Энэ гэрээ хэлцлүүд яг хэзээ эхэлсэн юм? Хэн хэн хаана очиж яриа хэлцэл хийсэн юм? Ямар бичиг баримтаар тэр нь баталгаажсан юм? Тэгээд ямар нөхцөлүүдэд тусгагдсан юм гээд огноотой нь сонсмоор байгаа байхгүй юу.

Түрүүчийн онгоцны түлштэй холбоотой гэхэд л нууцын зэрэг давсан юм уу. Ямар ч байсан ил биш урьдчилсан тийм яриа хэлэлцээ, бичиг баримтууд байгаа гээд байгаа юм.

Үнэхээр тийм баримт бичгүүд байгаа бол тэрийг нь Улсын Их Хурал дээр авч үзэх хэрэг байна.

Эдийн засгийн сайд хэлэх юм уу? Хэзээ эхэлсэн юм, ямар зорилгоор эхэлсэн юм, улс төрийн хэлцэл, гадаад харилцааны агуулгатай нь хаана явсан юм, эдийн засгийн агуулгатай нь хаана явсан юм, хэн хийсэн юм, эхний яриа хэлцлүүдийг. Энэ тоонуудыг сонсмоор байна. Асуулт нь.

Хариулт нь, өнөөдрийн ярьж байгаа олон зүйлүүд хэд хэдэн юм засахгүйгээр худлаа шүү гэдгийг сануулж хэлмээр байна.

Тэр Японы гэрээ хэлцэлтэй холбоотой ч тэр, Улсын Их Хурал дээр яригдаж байгаа хэд хэдэн яриан дээр зүгээр худлаа сонсоогүй бол бизнес эрхлэгчдээ буруутгасан өнгө аястай хэд хэдэн тайлбар явах шиг болсон.

- Бизнесийн орчин ч ийм.
- Дарамт шахалт нь өндөр.
- Татвар нь өндөр.
- Зөвшөөрөл нь хэцүү.
- Зүгээр бизнес хийж болдоггүй.

Жоохон ашиг олоод мөрөөдлөө биелүүлээд юм босоод ирэхээр хууль хүчний байгууллага нь орж ирээд улс төрийн захиа даалгавраар энд тэндээс нь чангаад хавчаад байдаг.

Урагшаа алхах гэхээр хууль тогтоомж, төрийн захиргааны байгууллагуудын маш олон зүйл нь ойлгомжгүй. Ойлгомжгүй болгон нь яг хавх шиг асуудалд оруулдаг. Тэгээд Засгийн газар нь хуулиас гадуур дураараа бүгдийг өөрчилдөг.

Та бүхэн санаж байгаа шүү дээ. Махны яг гадагшаа борлуулах бизнесийг нээгээд аятайхан бизнес эрхлэгчид төлөвлөөд, зээл аваад, үйлдвэр бариад яг гардгийн даваан дээр зүгээр л Засгийн газар нэг өглөө мах гаргахгүй гээд л хорьчихож байгаа байхгүй юу. Зарласан шүү дээ.

Гэх мэтчилэн. Ингээд зүгээр л өглөө босоод гэнэт сэрээд өөрсдийнхөө дураар бизнесийн төлөвлөлтийг нь өөрчилж болдог ийм орчинтой байгаа үед зах зээл нээгээд бизнес эрхлэгчдэд шинэ боломж гэхээсээ илүүтэйгээр шинэ өрсөлдөөн орж ирээд тэгээд л дарамтлал болно шүү.

Энэ бизнесийн орчноо сайжруулах алхмуудаа нэн даруй хийхгүй бол шинэ зах зээл гэж ярьж байгаа боловч энэ нь шинэ өрсөлдөөн, шинэ гаднын дэд бүтэц нь хөгжихсөн, ямар нэгэн байдлаар том масс үйлдвэрлэл явуулдаг болчихсон тэр хэсэгтээ илүү давуу байдал олгох боломжтой тийм зүйл шүү гэж хэлэхийг хүсэж байна.

Тэр цаг хугацааны хуваарийг нь би сонсмоор санагдаад байна. Эзэнтэй нь.

Г.Тэмүүлэн: Х.Тэмүүжин гишүүний асуултад Л.Гантөмөр сайд хариулъя. Дараа нь Ж.Энхбаяр сайд.

Л.Гантөмөр: Х.Тэмүүжин гишүүний асуултад хариулъя.

Ер нь Х.Тэмүүжин гишүүнтэй хойноос нь хариулъя. Санал нэг байна. Бид эдийн засгийн орчноо цэвэрлэж, өрсөлдөх боломжийг нь нэмэгдүүлж, жоохон эрүүл болгохгүй бол ийм хэлэлцээрүүд амилахгүй байна.

Тийм учраас эдийн засгаа илүү эрүүл саруул болох хэрэгтэй, илүү бизнес нь чөлөөтэй болох ёстой. Хөрөнгө оруулалт ядаж орж ирэхэд саадгүй болдог гэх мэтчилэн бидэнд хийх ажил их байна. Бид гэрийн даалгавраа хийх учиртай.

Ер нь Евразийн эдийн засгийн холбоотой хийх хэлэлцээрийн тухайд 2050 бичиг баримтыг батлахад энд оруулсан юм билээ. Хөрш орнуудынхаа эдийн засгийн интеграцид орно гэдгийг. Энэ дагуу эхний шат нь 2021-2030 оны хооронд Евразийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулна гээд орсон.

Тэгээд 2030 он ойрхон ирсэн байгаа. Одоо энэ хэлэлцээр байгуулагдахад 2026 он болно. Тэгэхээр 6 жил ажиллаж байгаа гэж ойлгох хэрэгтэй.

▷ 2020 оны 9 сард чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах, судлах хамтарсан судалгааны ажлын хэсэг байгуулагдсан. 2020 оны 9 сард.

▷ 2021 онд бүх бараан дээр хийгдэх, эсвэл бүх бараагаа тэглэсэн тохиолдолд Монголд ашиггүй гэдэг судалгаа гарсан. Гарсан.

▷ 2022 оны 11 сарын 24-нд Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар Орос Монголын Засгийн газар хоорондын комиссын хуралдааны үеэр асуудлыг тавьсан. Хэлэлцээр байгуулах асуудлыг тавьсан.

▷ 2023 оны 09 сарын 21-нд Оросын Холбооны Улсын Владивосток хотноо зохион байгуулагдсан Дорнын эдийн засгийн чуулга уулзалтын үеэр Засгийн газрын орлогч дарга А.Оверчук дангаараа Оросын Холбооны Улс татвараа тэглэх боломжгүй.

Тийм учраас Евразийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулъя гэдэг саналыг тавьсан.

▷ Энэ дагуу 2024 оны 01 сарын 28-нд анхдугаар зөвлөлдөх уулзалтыг Улаанбаатар хотод зохион байгуулсан. Евразийн эдийн засгийн холбооны комиссын хариуцсан сайд нар, дарга нар Монголд ирж 2024 оны 01 сарын 28-нд анхны хурлыг хийсэн.

▷ Хоёрдугаар хурлыг 2024 оны 03 сарын 13-нд Эдийн засаг, хөгжлийн яамны дэд сайд Г.Түвдэндоржоор ахлуулсан ажлын хэсэг очиж хуралдааныг зохион байгуулсан байдаг.

▷ Ингэж явж байгаад 2024 оны 07 сарын 2-нд эхний шатны хэлэлцээрийг байгуулсан.

Тэгээд бид үндсэндээ Монголын дотоодынхоо үйлдвэрлэлийг үнэхээр хамгаалах шаардлага байна гэдэг зүйлийг манай Худалдаа, аж үйлдвэрийн танхим, холбоод, мөн Хүнс, хөдөө аж ахуйн яам санал, санаачилга гаргаад асуудлаа дэвшүүлсэн.

Яг энэ асуудлын хүрээнд Их Хурлын гишүүд санал гаргасан. Энэ саналын хүрээнд бид дараагийн хэлэлцээр дээрээ 23 нэр төрлийн барааг тарифын хөнгөлөлт, чөлөөлөлтөөс хасъя гэдэг саналыг дэвшүүлсэн.

Энэ санал бидний хүсэж байсан хэмжээнд 100 хувь шийдэгдээгүй ч гэсэн түрүүн Ж.Энхбаяр сайд танилцуулсан. Гол дотоодын үйлдвэрлэлээ хамгаалах хэмжээний хэлэлцээрийг бид хийж дуусгаад миний бие 2025 оны 03 сарын 20-нд Евроази дээр өөрөө очсон. Өөрөө урьдчилсан байдлаар гарын үсэг зураад ирсэн ийм зүйл байгаа.

Г.Тэмүүлэн: Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Нэг ташаа мэдээлэл явлаа.

Махан дээр ямар нэгэн хязгаарлалт хийсэн зүйл байхгүй. Харин махны экспортыг бүх талаар урамшуулж байгаа. Тавигдаж байсан квот болон бүх хязгаарлалт чөлөөлөгдсөн.

2024 оны гүйцэтгэлээр 300 гаруй сая долларын мах экспортод гарсан. Махны зах зээлийг бид олон зах зээл, олон тулгуурт болгох бодлого явуулж байгаа. Жишээлбэл, ямааны мах Вьетнамд тулгуурласан Зүүн Өмнөд Азийн зах зээл, хонины махыг Арабын орнууд, Ойрх Дорнодын орнууд, Төв Азийн орнууд, хоёр хөрш гэх мэтийн зах зээлийг бүх талаар дэмжиж идэвхжүүлж байгаа.

Мал, мах бэлдсэн, гэрээ хийсэн бүх аж ахуйн нэгжүүд чөлөөтэй, хязгаарлалтгүйгээр экспорт хийж байгаа.

Та сар шинийн өмнө зарим газар мах авч нөөцлөх, зохиомол үнэ өсгөх оролдлого гарсан. Үүнийг зохицуулах үүднээс бид экспортод гарч байсан үйлдвэрүүдтэйгээ яриад өргөтгөсөн худалдаа, нийлүүлэлтийг дотооддоо идэвхжүүлсэн. Өнөөдрийн байдлаар инфляц бага байгаад хамгийн их нөлөөлсөн нь махны үнийн уналт буюу махны хүрэлцээ, нийлүүлэлт тогтвортой байгаа нь энд их эергээр нөлөөлж байгаа.

Тэгэхээр бид махаа цаашид ер нь нэлээн том экспортын гол бүтээгдэхүүн болгох бололцоотой. 300 сая доллар хүрч байна. Ирэх жил гэхэд бид 500 сая долларт хүрэх бололцоотой.

Ноолуур дээр 404 сая долларын экспорт хийгдсэн. Үүнийг одоо энэ техникийн зохицуулалт буюу самнасан хэлбэрт бид ээрэх, сүлжих чадвар, чанараа сайжруулах юм бол энэ ойрын хугацаанд багаар бодоход 600-аас 800 сая доллар луу экспортын чадавх нэмэгдэх тооцоо гарч байгаа.

Тэгэхээр энэ гэрээ, хэлэлцээрээс манай мал аж ахуй, мах, махан бүтээгдэхүүн, арьс, ширэн бүтээгдэхүүн, ноос, ноолууран бүтээгдэхүүнд маш таатай байдал үүснэ гэдгийг ойлгоорой.

Г.Тэмүүлэн: Э.Бат-Амгалан гишүүн асуулт асууя.

Э.Бат-Амгалан: Гурван асуулт байгаа юм.

Үндсэндээ яах вэ, Евразийн эдийн засгийн холбооны худалдааны түр хэлэлцээрийг том агуулгаар нь дэмжиж байгаа. Гурван асуулт байна.

Энэ ер нь оруулж ирэхдээ сая хэдэн оноос эхлээд явсан, яасныг нь Л.Гантөмөр сайд хэлж л байна л даа. Энэ судалгаа, хэлэлцүүлэг ямар ямар шатад явсан бэ? Мэдээлэл авахад жишээ нь Монгол Улсын Их Сургууль, Эдийн засгийн сургуулийн судлаач нар Худалдаа, аж үйлдвэрийн танхимынхны

гаргасан дүгнэлтүүд гээд янз бүрийн юмнууд байна. Энд орох нь бидэнд ашиггүй, дэмий гэсэн нэг ийм дүгнэлтүүд гарчихсан явж байх юм.

Эрдэмтэд, судлаач нараас гадна бид бас энэ үндэсний үйлдвэрлэгч нараасаа, аж ахуйн нэгжүүдээсээ, ялангуяа экспорт хийдэг үйлдвэрлэгч нараасаа хэлэлцүүлэг хийгдсэн үү? Тэндээс судалгаанууд авсан асуудлууд байна уу? Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал, Хөдөө аж ахуйн сайд сая хэлж байна л даа. Чөлөөтэй, хязгаарлалтгүй одоо ингээд экспорт хийж байгаа гэж. Яах вэ, квот хязгаарлалтгүй болсон, татвар тэглэх, янз бүрийн юм багасгах асуудлууд байх нь тодорхой байх. Хэрвээ энэ гэрээ хийгдсэнээр. Гэхдээ эргээд нэг л асуудал яг энэ дээр гараад байдаг юм шиг харагдаад байгаа юм. Ерөөсөө бид тэр нийлүүлэх гэж байгаа орныхоо стандартыг хангаж чадахгүй ийм л асуудал.

Тэгэхээр Хөдөө аж ахуйн яам, ер нь цаашдаа энэ гэрээ хийгдэх юм бол энэ стандартын асуудал дээр бид ямар чиг баримжаа барьж явах юм бэ? Нийлүүлнэ л гээд байдаг. Нөгөө талаас бараанууд орж ирээд байдаг. Бид экспортоо хийх гэхээр танай хонины мах ийм байна, ямааны мах ийм ийм асуудалтай, стандарт байхгүй учраас хүлээж авч чадахгүй нь гэдэг асуудал. Цаашид гарах үр дагаврууд дээр ямар арга хэмжээ авч, ямар шийдвэртэй ажиллахаар төлөвлөж байгаа юм бэ гэж.

Гурав дахь асуудал. Энэ хэрвээ Евроазийн эдийн засгийн худалдааны түр хэлэлцээрийн төсөл Их Хурлаар орно. Дэмжигдэхгүй бол цуг явж байгаа Засгийн газраас өргөн барьсан агаарын хөлгийн түлш нийлүүлэх асуудал бас үүнтэй холбоотой явж байгаа юу, эсвэл тусдаа гэрээгээр явж байгаа юу?

Гадуур бол бас нэг тийм холбоотой юм шиг ийм мэдээллүүд яваад байгаа юм. Ийм гурван асуудал байна.

Г.Тэмүүлэн: Э.Бат-Амгалан гишүүний асуултад хариулъя. Л.Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Ийм байгаа. Энэ Евразийн эдийн засгийн холбоотой худалдааны хэлэлцээр хийе гэдэг санал 100 хувь Монголын талаас гарсан санал.

Тийм учраас энэ өөрөө ямар нэгэн Оросыг Холбооны Улстай хийж байгаа бусад яриа хэлэлцээртэй холбоо бол ерөөсөө байхгүй. Энэ бол одоо яг Ө.Энхтүвшин сайд өнөөдөр Оросын Холбооны Улсад Элчин сайд байдаг. Ө.Энхтүвшин сайдын надад өгч байгаа мэдээлэл бол өөрөө Шадар сайд байхдаа эдийн засгийн комисс дээр очиж танай холбоотой гэрээ хийе гэж хоёроос гурван удаа санал тавьсан байдаг. Харамсалтай нь хүлээж аваагүй гэж өөрөө хэлдэг.

Яг ярьж эхэлсэн, зөвшөөрөгдөж эхэлсэн цаг хугацааг би түрүүн гишүүний асуултад хариулахдаа хэлсэн. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, түрүүчийн тэр түлш шатахуунтай холбоотой асуудал бол ерөөсөө л Оросын Холбооны Улсаас нийлүүлж байгаа дизелийн түлш А92, А80 гэсэн энэ бензинүүдийн нийлүүлэлтийг тогтвортой байлгахын тулд гэрээ хийе гэдэг асуудал яригдсан.

Яагаад гэвэл Оросын Холбооны Улс энэ дайн, тулалдааны үед гадагшаагаа бензин зарахгүй гэсэн юм. Тэгээд Монгол бид бензин танайхаас авахгүй бол өөр нийлүүлэх газар алга гэдэг асуудлаа тавьдаг.

Ингээд нийлүүлэлтээ хэвийн байлгая. Хэвийн байлгая гэхээр дахиад энэ геополитикийн нөхцөл байдал их тогтворгүй байгаа учраас Монголын тал өөрөө тогтвортойгоор бензин та нар нийлүүлээч ээ гэдэг асуудал тавьдаг.

Тэгэхээр нөгөө тал тэгвэл бид энэ онгоцны шатахууныг чинь бас ингээд тогтвортой нийлүүлмээр байна. Энэ дээрээ та нар гэрээ хийж өгөөч ээ гэдэг ийм л асуудал яригдсан байх.

Яг Евразийн хэлэлцээртэй тусдаа шүү гэдгийг гишүүнд хэлье.

Тэгээд нэмээд нөгөө процесстой холбоотой зүйл дээр 3 номерын микрофоныг өгчхөөрэй. Гишүүний асуултад хариулъя.

Г.Тэмүүлэн: 3 номер нэмж тайлбар өгье.

Б.Анар: Олон нийтийн хэлэлцүүлэгтэй холбоотой 2023 онд 2 удаа, 2024 онд 2 удаа Худалдаа, аж үйлдвэрийн танхимуудтай хамтраад. 2025 онд нийтдээ 4 удаа. Ингээд 8 удаагийн давхардсан тоогоор 400 гаруй аж ахуйн нэгж оролцуулсан ийм олон нийтийн хэлэлцүүлгүүдийг Хөдөө аж ахуйн яам, Худалдаа, аж үйлдвэрийн танхимтайгаа хамтраад хийсэн.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас хийж байгаа худалдааны хэлэлцээрийг байгуулахад ерөнхий тэнцвэрийн загвар гэдэг загвар дээр эдийн засгийн судалгаа, тооцоог хийдэг.

Бусад та нөгөө МУИС-ийн багш нарын хийсэн судалгааг асуугаад байх шиг байна. Тэр одоо яг ямар хаанаас захиалгатай судалгаа хийгдсэнийг бол. Мэдэхгүй. Бид хэд хамтраад судалгаагаа, үр дүнгээ харьцуулаад үзье гэдэг хүсэлтийг тавьсан. Одоо болтол судалгааны үр дүн бид нарын гар дээр нэгд ирээгүй байна.

Импорттой холбоотой нийт орж ирж байгаа импортын 70 хувь нь түлш, шатахуун байдаг.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: 3 номер. Нэмээд микрофон өгье.

Б.Анар: Тэгэхээр 2014 онд бид 1 тэрбум долларын хэмжээний түлш шатахууныг Оросын Холбооны Улсаас жишээ нь импортоор авч байсан. Энэ хэмжээ 2024 онд 2.1 тэрбум доллар.

Тэгэхээр бид хэд угаасаа өөрсдөө үйлдвэрлэж чадахгүй байгаа бүтээгдэхүүнүүдээ импортоор авч байгаа. Энэ бусад улстай хийсэн худалдааны хэлэлцээр дээр ч гэсэн ажиглагддаг. Хийж чадахгүй байгаа бүтээгдэхүүний импорт татвартай байсан ч, татваргүй байсан ч өөрөө нэмэгдэж байгаа.

Бидний зүгээс анхаарч байгаа гол асуудал нь юу вэ гэхээр экспортод гаргаж чадах бүтээгдэхүүн дээрээ л илүү түлхүү анхааръя гэсэн зорилгоор энэ хэлэлцээрүүд явж байгаа. Хэлэлцээр бол ашигтай хэлэлцээр байгаа.

Г.Тэмүүлэн: Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Гадаад худалдаа яах аргагүй чанар стандартыг худалдан авагч тал тавьдаг. Худалдан авагч талын хорио цээрийн байгууллагууд ирж магадлан итгэмжилж өөрийн стандартыг нэвтэрсэн эсэхийг заавал баталгаажуулдаг.

Махны экспортыг бид олон жил ярьсан. Бараг 30 жил ярьсан. 20 сая, 30 сая доллароос хэтэрч үзээгүй. 300 сая долларын экспорт хийдэг болсон. Тэр болгонд л бид энэ стандартыг сайжруулах, үйлдвэрүүдээ тоног төхөөрөмжөө сайжруулах ажлууд хийгдсэн. Ялангуяа сүүлийн үед энэ “халал” стандарт буюу исламын шашинтай орнуудын зах зээл гарах чиглэлээр маш сайн ажилласан.

Ийм учраас одоо Хэнтий аймагт бэлтгэгдсэн мах 48 цагийн дотор Арабын орнуудад онгоцоор очиж байна шүү дээ. Манай бэлтгэгдсэн мах Зүүн Өмнөд Азийн зах зээл, Вьетнамын зах зээлд ямааны мах очиж байгаа.

Тэгэхээр хувийн хэвшлийнхэн маань их хичээсэн. Тэгээд тэр стандартыг хөврүүлэх, энэ хоёр улсын хорио цээрийн байгууллага, мал.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: 1 минут Ж.Энхбаяр сайдад нэмж өгье.

Ж.Энхбаяр: Хоёр талын хорио цээр, мал эмнэлгийн байгууллагуудын хийсэн гэрээ, протоколууд гээд олон зүйл бий.

Тэгэхээр ер нь их үр дүн нааштай. Үр дүн ерөөсөө л экспортоор. Мэдээж сайжруулах юм байна. Бид нарт бас. Улам сайжруулах хэрэгтэй. Улам үнэтэй

зах зээлд гарахын тулд улам л бид өөрсдөө өөрчлөх хэрэгтэй. Бид гэрийн даалгавраа л сайн хийх хэрэгтэй. Улам олон улсын түвшинд илүү сайн баталгаа гаргах тийм стандартыг нутагшуулахын төлөө л бүгдээрээ явах ёстой.

Тэгэхээр энэ махны экспорт нэмэгдэхээр мал аж ахуйд их том өөрчлөлт гарч байна. Малыг бордож эхэлж байна, өсвөр малыг тэжээж эхэлж байна. Тэгээд үйлдвэрийн аргаар нядалгаанд орохоор гарч байгаа түүхий эдийн чанар эрс сайжраад, нөгөө арьс ширний үйлдвэрүүдийн түүхий эдийн нийлүүлэлт их сайжирч эхэлж байна буюу гэмтэлгүй үйлдвэрийн боловсруулсан арьс үйлдвэрүүд дээр ороод эхэлж байна.

Мал, мах экспортод гараад ирэхээр малчдын орлогод их том нөлөө. Зөвхөн ганц ноолуур биш, мах их том нөлөө үзүүлж эхэлж байна.

Тэгэхээр ирээдүйн боломж энд их өндөр байна гэж хэлэх гэж байна.

Г.Тэмүүлэн: Э.Бат-Амгалан гишүүн нэмж тодруулъя.

Э.Бат-Амгалан: Энэ 400 гаруй аж ахуйн нэгжүүдтэй хэлэлцүүлэг хийсэн гээд сая тоо хэлж байна.

Зүгээр хэлэлцүүлэг хийсэн гэдэг нь яах вэ? Хэлэлцүүлгээс ямар үр дүн гарсан юм бэ? Аж ахуйн нэгжүүд маань дэмжсэн юм уу? Хэдэн хувь нь орсон юм? Тэнд янз бүрийн протокол, тэгээд дүгнэлтүүд юу гарсан юм бэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, яах вэ, Ж.Энхбаяр сайд гараад явчихлаа л даа. Ж.Энхбаяр сайдаас асуусан гол юм нь болохоор энэ стандартад нийцүүлэх талаар ер нь Монгол Улсын Засгийн газар танай яам яг цаашдаа юу хийхээр, ямар арга хэмжээ авч ажиллах гэж байгаа юм бэ гэдэг л ийм л асуудал.

Нэг жишээ хэлэхэд байна шүү дээ. Өнгөрсөн жил хэдэн тонн мах экспортолсон юм? Одоо энэ худалдааны хэлэлцээрт орсноор цаашдаа хэдий хэмжээний, ямар тоо толгойтой, хэдэн сая долларын хэдэн сая тонн гэдэг юм уу мах экспортолж чадах юм бэ гэж харж байгаа юм бэ л гэж л асуусан юм.

Г.Тэмүүлэн: Хөдөө аж ахуйн яам. 5 номер. Нэр, албан тушаалаа танилцуулаад асуултад хариулъя.

Ч.Болорчулуун: Э.Бат-Амгалан гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Болорчулуун.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан дэд ажлын хэсэг байгуулагдсан. Нийтдээ 18 салбарын төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг 2 удаа хийсэн.

Үүний үр дүнд нийт явж байсан 375 бүтээгдэхүүн дээрээс 23 нэр төрлийн барааг хасуулах саналтай байна гэдэг шийдвэр ажлын хэсэг дээр гарсан. Энэ тухайгаа Эдийн засаг, хөгжлийн яаманд үүнийг албан хүсэлтээр хүргүүсэн.

Үүнээс 8 бүтээгдэхүүн хасагдаад, 4 төрлийн бүтээгдэхүүн дээр тодорхой хэмжээний квот, татварын хөнгөлөлттэй нөхцөлтэй шийдвэр эцсийн байдлаар ирсэн. Тухайлах юм бол хүнсний улаан буудайн дээр 5 мянган тоннын квот квоттой.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Ж.Энхбаяр сайд сая ийм асуулт асуусан. Ж.Энхбаяр сайд аа, Э.Бат-Амгалан гишүүн энэ тарифын бус хориг саадыг багасгахтай холбоотойгоор Хөдөө аж ахуйн яам ирэх жил ямар ажил хийх гэж байгаа юм бэ? Одоо бид ер нь махан дээр, ер нь стандартад нийцүүлэх асуудлаар Хөдөө аж ахуйн яам яг ямар ажил хийх гэж байгаа юм? Энэ жил болоод ирэх жил ямар ажлууд хийх гэж байгаа юм? Тэгээд хэлэлцээр байгуулдаг. Хэлэлцээрийнхээ дагуу стандартад нийцүүлэх, бараа, бүтээгдэхүүнээ экспортлох тал дээр яг ямар ажил хийх гэж байгаа юм гэдэг асуудлыг асуугаад байгаа юм. Та энэ дээр хариулах уу? Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Улсын Их Хурлын баталсан бодлогын хөтөлбөрүүд байгаа.

“Цагаан алт” хөтөлбөр, арьс шир, ноос, ноолуурынхаа боловсруулалтын түвшнийг сайжруулах. Энэ ажлууд хийгдэж байна. Ноосон дээр, ноолууран дээр, арьс, ширийг хэрхэн боловсруулалтаа сайжруулах вэ, экспортын чиг баримжааг хэрхэн шилжүүлэх вэ.

Нөгөө талаар “Атрын-IV” аяны хүрээнд тэжээлийн таримлын эрс нэмэгдүүлэх. Үүн дээрээ тулгуурлаж мал бордох аж ахуйнуудыг олноор бий болгох, ялангуяа үхэр сүргийн тоонд онцгой анхаарч байгаа. 200 мянган толгой мах сүүний ашиг шимт үхрээр үхэр сүргийг сэлбэх зайлшгүй шаардлага байгаа.

Яагаад гэвэл хамгийн том зах зээл үхрийн махан дээр байгаа. 50 хувийн татвартай. Үхрийн мах тэг болж орж байгаа дээр манайд маш том орон зай гарч байгаа.

Тэгэхээр бид газар тариалан дээрээ тулгуурласан махны экспортын чигтэй ийм хамгаалагдсан аж ахуйнуудыг хөгжүүлэх бололцоо гарч ирж байгаа юм.

Хорио цээрийн ажлууд хийнэ. Одоо хэлэлцээрийн хүрээнд Оросын Холбооны Улсын мал эмнэлэг болон хорио цээрийн байгууллагуудтай харилцан гэрээ протоколуудаа хийнэ. Тохирох асуудлуудаа. Энэ дээр ингэнэ ингэнэ. Хамтарсан вакцин, угаалга, туулга, үйлдвэрийн тэр бүх шат дамжлага болон хоёр талын стандартаа тохироод. Хамгийн гол давуу тал нь харьцангуй олон улсын өндөр түвшний хорио цээрээс илүү. Одоо хоёр талдаа тохирч чадвал

явах бололцоо нь илүү. Харьцангуй жоохон сул гэсэн үг. Бидний хувьд боломжтой гэсэн үг.

Тэгээд энэ талаараа тохиргоонуудаа хийх том ажлууд эхэлнэ. Мэдээж 2026 оны төсөв дээр ялангуяа лабораториудын, хил худалдаанд лабораториудыг нэлээн сайжруулах хэрэгтэй байна.

Биокомбинатынхаа вакцин үйлдвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Хил дээр гарч байгаа мал мах экспортлох үеийн тэр хорио цээрийн байгууламжууд ерөөсөө дутуу байгаа. Тэрийг хийх ажил байна. Тэгээд хувийн хэвшилтэй мал бэлтгэх.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: 1 минут Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Энэ үйлдвэрүүддээ мал, мах бэлдэхэд нь зориулаад эргэлтийн хөрөнгөөр жоохон дэмжээд өгөх хэрэгтэй байна.

Ер нь манайх бэлчээр 20 сая толгойгоор давчхаад, бэлчээрийн талхалт их өндөр. Нөгөө цөлжилтөд нэрвэгдэх байдал их өндөр яваад байгаа юм.

Тэгэхээр экспортын чанартай мал аж ахуйгаа хөгжүүлснээр манайх бэлчээрийнхээ асуудлыг шийдье. Энэ цөлжилтийн асуудлуудын ард нь гаръя. Ингээд үр ашигт байдал. Тэгээд газар тариалан дээрээ тулгуурласан тэжээлийн тариа тарих, олон сэлгээнд оруулах бодлогоо хэрэгжүүлээд явахад мал аж ахуйгаа, газар тариалангаа хослолыг сайн хийгээд, энэ дээр тулгуурласан хөнгөн хүнсний үйлдвэрүүдээ экспортын чиг баримжаатай болгох ийм бодлогыг “Атрын-IV”, “Цагаан алт”, “Шинэ хоршоо”, “Хүнсний хувьсгал” чинь бүгд хоорондоо уялдаатай байгаа юм. Бие биеэ харилцан нөхсөн, бие биеэ дэмжсэн энэ 4 хөтөлбөр Улсын Их Хурлаар батлагдаад хэрэгжиж байгаа.

Тэр хүрээнд харьцангуй бид бэлэн байдалд байна.

Г.Тэмүүлэн: Э.Бат-Амгалан гишүүний асуулт дээр нэмж хариулья. Аж ахуйн нэгжүүдтэй холбоотой дүгнэлт гаргасан эсэх гэдэг асуудлыг асуусан байсан. Хэн хариулах вэ? 5 номер.

Ч.Болорчулуун: Дэд ажлын хэсэг дээр энэ 18 төрийн бус байгууллагын төлөөлөл оролцоод саналууд гарсан байгаа.

Нийтдээ 23 нэр төрлийн бүтээгдэхүүнийг одоо энэ Евроазийн чөлөөт худалдааны түр хэлэлцээрээс хасуулья гэдэг санал явсан. Гарсан. Энэ саналыг бид Эдийн засаг, хөгжлийн яаманд уламжилсан байгаа.

Энэ хэлэлцээр яваад сүүлийн хэлэлцээрээр тодорхой тооны бүтээгдэхүүнүүд дээр, тодорхой тоо хэмжээний квот, татварын тарифын

хөнгөлөлт гарч ирсэн. Тухайлах юм бол, хуурай сүүн дээр 1500 тонныг оруулъя гэдэг эцсийн байдлаар шийдвэр ирээд байгаа.

Түүнчлэн улаан буудайн дээр 50 мянган тонныг 3.75 хувийн татварт оруулъя гэдэг шийдэл ирсэн байгаа. Сүүлийн ирсэн мэдээлэл ийм байдалд хүрээд л зогссон байж байгаа.

Г.Тэмүүлэн: Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Үндэснийхээ аж ахуйн нэгжүүдийг хамгаалах бодлогыг давхар авч явах ёстой. Жишээлбэл, өндөг гэхэд бид 90 сая өндөг импортлох үүрэг хүлээж байгаа юм.

Тэгэхээр энэ 90 саяыгаа би шувууны холбоо, өндөгний аж ахуй хийж байгаа компаниуддаа өгье гэж байгаа юм. Өөрсдөө үйлдвэрлэж байна. Эд нар импортоо давхар авч яваад нэг үнийн бодлогоо бариад явчих. Ингэвэл тогтвортой байдал буюу үйлдвэрлэлийнхээ юмаа зохицуулаад явах бололцоотой юм болов уу? Энэ мэтчилэн дандаа холбоодтойгоо, тэд нартаа энэ давуу байдлыг олгосон, хамгаалалтыг хийсэн юмнуудыг явуулна.

Нөгөө талаас сая Засгийн газар дээр Ерөнхий сайд үүрэг өгөгдөөд энэ бүсийн хөгжлийн бодлоготой холбоотойгоор салбарыг хэрхэн хөгжүүлэх вэ чиглэлээр татварын иж бүрэн реформ хий гэдэг үүрэг, тэр төслийг бэлд гэдэг Сангийн яаманд, Хөгжлийн яаманд үүрэг өгсөн. Ингээд ажиллаж байгаа.

Тэгээд энэ чиглэлээр бид хамгаалах татварын зохицуулалтуудыг хийх бололцоо байгаа.

Г.Тэмүүлэн: Э.Бат-Амгалан гишүүн болсон уу? Тийм ээ. Б.Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Өчигдөр Эдийн засгийн байнгын хорооны хурал яг энэ танхимд энэ асуудлаар болсон.

Тэгээд гишүүд маш олон чиглэлээр асуултууд асууж байсан. Тухайлах юм бол одоо манай дотоодын компаниудын өрсөлдөх чадвар, энэ хорио цээрийн асуудал, тарифын бус саад тотгорууд, төлбөр тооцооны асуудал гэх мэтчилэн энэ хэлэлцээртэй холбоотой маш олон асуудлууд байгаа.

Тэгээд энэ тал дээр Улсын Их Хурлын гишүүд маш ихээр санаа зовж байна. Энэ танхимд ч гэсэндээ тийм уур амьсгал ажиглагдаж байна. Тэгээд эргэлзэж байгаа. Дотоодын зах зээлдээ хамгийн гол нь санаа зовоод байгаа юм.

Тэгэхээр ийм их эргэлзээ тээнэгэлзээ байхад манай сайд нар ийм дөргүй бух шиг үгүй та нар ойлгохгүй байна, та нар албаар эсрэг юм яриад байна. Энэ

бол манай улсад маш их ашигтай хэлэлцээр гээд бас дайраад байх нь зохимжгүй санагдаад байна л даа.

Яагаад вэ гэхээр бид чинь хамгийн нэн түрүүнд дотоодынхоо зах зээлийг хамгаалах, энэ үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, Монгол хүмүүсийнхээ ажил орлогыг бодох ийм үүрэгтэй хүмүүс шүү дээ.

Тэгэхээр албаар тэгж эсрэгцээд байгаа юм бол байхгүй гэдгийг хэлмээр байна.

Тэгээд яамнаас манай талд ашигтай л гээд байгаа. Тэгээд яг хойшоо юу зарах юм гэхээр нөгөө мах, ноос, ноолуур гээд дуусаж байгаа юм. Би тэгээд өнгөрсөн хугацаанд зөндөө олон компаниудтай ярилаа. Монголын томоохон мах, махан бүтээгдэхүүн боловсруулагч компанитай ярилаа. Та нар хойшоо мах гарга гэвэл хэчнээн мах гаргаж чадах вэ гэсэн чинь сардаа 200 тонныг махийж байж гаргана гэж байна. Тийм.

Үгүй. Би ярьсан юмаа л ярьж байна.

Тэгэхээр одоо жишээлбэл 50, 60 сая малынхаа тоо толгойг үржүүлээд 150 мянган тонн гэсэн хийсвэр тоо гаргаж ирээд тэгээд тэрийгээ тооны машин энэ дээр бодоод явж болохгүй шүү дээ. Бид нарын одоо энэ нэг зах зээлийн чинь хязгаарлагдаж байгаа хүчин зүйлүүд байгаа шүү дээ.

Тэгэхээр одоо хэрэв бид жишээлбэл өөрсдийгөө сорьж үзье гээд байгаа юм бол нөгөө л нэг Япон руугаа яригдаад байгаа, тэр Европын Холбоо руу ч гэсэндээ тарифгүй гаргах боломжууд байгаа. Гэтэл өмнөх байгаа боломжуудаа ашиглахгүй байж одоо ингээд цоо шинээр нэг ийм юм оруулж ирчхээд зөндөө их эргэлзээ байхад ингээд дайраад байгаа байхгүй юу даа. Тэр чинь л аягүй хэцүү нөхцөл байдалд үүсгээд байгаа юм.

Тэгээд сая хэдхэн хоногийн өмнө Оросын Холбооны Улсын нэг нэр бүхий MAIL.RU-гийн мэдээн дээр ийм мэдээ гарсан байна л даа. Ийм нөхөрсөг бус валютаар арилжаа хийх явдлаа зогсоолоо гээд.

Тэгээд 2025 оны эхний 2 сарын байдлаар Орос Улс импортынхоо төлбөр тооцооны 53.5 хувийг рублиэр төлдөг болчихсон юм байна.

Тэгэхээр энэ төлбөр тооцоон дээр одоо жишээлбэл энэ рублиэр төлөгдөх асуудал орж ирэх юм бол манай мөнгөний бодлого, валютын нөөцөд яаж нөлөөлөх вэ гэдэг асуултыг юуны түрүүнд асууя. Яагаад вэ гэхээр яг аюулгүй байдал талаасаа энэ асуудлууд чухал гэж ойлгож байна.

Тэгээд өчигдөр Эдийн засгийн байнгын хороон дээр энэ төлбөр тооцоогоо яаж гүйцэтгэх юм гэдэг дээр олигтой тайлбар өгөөгүй. Өмнө нь оны өмнөхөн бид бензинийхээ мөнгийг ч гэсэндээ шилжүүлж чадахгүй сууж байсан шүү дээ.

Тэгэхээр одоо ингээд худалдаа наймаа хийгээд үнэхээр аягүй их хэмжээгээр зараад байлаа гэж бодоход мөнгөө яаж авах юм бэ? Ямар валютаар авах юм бэ? Энэ нь манай мөнгөний бодлогод хэрхэн яаж нөлөөлөх юм бэ гэдэг тодорхой асуулт байна.

Тэгээд цаг хугацааны хувьд ер нь одоо яг хэзээ энэ хэлэлцээр чинь эхэлнэ гэж тооцоолж байгаа юм бэ?

Г.Тэмүүлэн: Б.Жаргалан гишүүний асуултад хариулъя. Л.Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Б.Жаргалан гишүүн ээ, Монгол Улсын Засгийн газар өөрөө мэдээд сайн дураараа нэг их асуудал хөндөөд, тэгээд түүнийхээ араас улайрдаг тохиолдол ер нь байдаггүй юм л даа.

Заавал Их Хурлаас гарсан баримт бичиг, Их Хурлаас гарсан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлдэг ийм үүрэгтэй.

Тийм учраас бид нэг их айхтар одоо дөргүй бух шиг зүтгээд байгаа зүйл байхгүй шүү дээ. Энэ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилтын 4.4-д байгаа юм. Орсон. Одоо ингээд энэ 6 жил болж байна.

2021-2030 онд хөрш орнуудыг дамжсан эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, Оросыг Холбооны Улстай чөлөөт худалдааны хэлэлцээр хийх гээд орсон. Худалдааны интеграцад нэгдэх гээд.

Тэгээд үүнийг чинь бид биелүүлэх үүрэгтэй шүү дээ. Тэгээд дээр нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5.1, 3.2.5.3, 3.2.5.4-д та нар энэ эдийн засгийг солонгоруул, эдийн засгийн харилцааг тэнцвэржүүл гээд үүрэг өгчихсөн шүү дээ.

Тэгээд үүргээ бид биелүүлэх гээд л зүтгэж байгаа хэрэг байхгүй юу даа. Үүргээ ямар нэгэн аргаар биелүүлье л гэж байгаа юм. Мэдээж Их Хурлын гишүүн бол үүрэг хүлээхгүй байж болно л доо. Засгийн газрын гишүүн бол үүрэг хүлээдэг байхгүй юу даа. Үүрэг хүлээх гэж энэ албан тушаал дээр бид очсон. Ард түмэн харж байгаа, Их Хурал харж байгаа.

Тийм учраас бид үүргээ биелүүлж байгаа юм шүү. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.2.11-д бүр нэрээрээ байгаа. Евразийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуул.

Одоо бүрэн эрхийн хугацаа чинь ингээд 8, 9 сар боллоо гээд Б.Жаргалан гишүүн бид нарыг загнаад байгаа.

Тэгэхээр бид хэзээ байгуулах юм энэ гэрээгээ. Үгүй, энэ чинь үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан. Одоо та 2 жилийн дараа надаас нэхнэ шүү дээ. Нөгөөдөх чинь яасан бэ, нөгөө батлагдсан юмыг минь чи яагаад хийдэггүй юм бэ гээд.

Тийм учраас хийж байгаа хэрэг шүү. Тэгэхдээ бид Монголдоо ашигтай байдлаар, энэ гарсан бичиг баримтууд бол “долоо хэмжиж нэг огтолсон” бичиг баримтууд. Энэ бичиг баримтууд бол яг үндэсний үзэл санаагаа дэмждэг. Монгол улс хэрхэн цаашаа босож ирэх вэ гэдгийг олон эрдэмтэн мэргэд, олон улс төрийн намууд нийлж байж гаргадаг ийм л бичиг баримтууд.

Тэгээд эд нарыгаа бид биелүүлж байгаа юм шүү гэдгийг нэгдүгээрт хэлмээр байна.

Хоёрдугаарт, Оросын Холбооны Улсаас Монгол руу хийж байгаа мөнгөн шилжүүлэг дээр асуудал гарахгүй. Манайхаас эсрэгээр нь хийж байгаа мөнгөн шилжүүлэг дээр өнөөдөр асуудал байгаа. Бид ямар нэгэн байдлаар шийдээд явж байгаа.

Тийм учраас манайх бараагаа зарах үед бид төлбөр дээр асуудал үүсэхгүй.

Хойд талаас одоо ингээд 5 улстай гэрээ хийж байхад нэгийг нь салгаж авч яриад байна л даа. Тэр салгаж аваад санаа зовниж байгаа улсыг нь онцгойлоод хэлэхэд нөгөө талаас манайх руу зарсан барааны төлбөр дээр магадгүй өнөөдрийн дэлхий нийтийн асуудал шийдэгдтэл проблем үүсэж магадгүй.

Валютын тухайд мэдээж олон улсынхаа валютаар л. Казахстан юу гэж л Казакын мөнгөн тэмдэгт, Киргиз юу гэж Киргизийн мөнгөн тэмдэгтийг шилжүүлнэ гээд суух вэ дээ. Тэгэх юм бол бид адилхан төгрөгөөрөө төлбөр хийнэ гээд л сууна шүү дээ. Энэ чинь адилхан харилцан эрх бүхий худалдаа хийж байгаа хоёр хүн чинь тохиролцдог юм байгаа биз дээ.

Тийм учраас энэ дээр Засгийн газар төлбөрийн аль нэг хэрэгслийг сонгож гэрээ хийхгүй ээ. Бид олон улсынхаа валютаар харилцан төлбөрөө хийгээд худалдаанууд явагдана гэдэгт эргэлзэхгүй байна.

Г.Тэмүүлэн: Б.Жаргалан гишүүн нэмж тодруулъя.

Б.Жаргалан: Яах вэ, Засгийн газар ажилласан гээд л байгаа. Маш нягт нямбай баримт бичиг болсон гээд л байгаа. Ашигтай байгаа л гээд байгаа.

Тэгсэн хэрнээ одоо жишээлбэл сая О.Номинчимэг гишүүний хөндөж тавиад байгаа тамхины татварын асуудал гэхэд л ингээд л л бусад бодлогуудтайгаа уялдаагүй ийм асуудал ороод ирсэн явж л байгаа.

Тэгэхээр хамгийн гол нь түүн дээр чинь эргэлзээд байгаа байхгүй юу даа.

Тэгээд нөхцөл байдал өөрчлөгдөж байгаа гэдгийг бид ялангуяа Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр ярих ёстой. Дэлхийн худалдааны дайн эхэлж байна. Нөгөө “Трамп тариф” энэ тэр гээд Засгийн газраас яриад л байгаа зүйлүүд дээр яг энд нөхцөл байдал өөрчлөгдөж байгаа зүйлүүд байна шүү дээ.

Тэгэхээр тэр болгон дээр бид маш их ухаан зарж байж асуудлаа шийдэхгүй бол нэг хөгжлийг хойш нь татаад байгаа хэсэг бүлэг хүмүүс энд суучаад яриад байгаа юм шиг хандаж болохгүй.

Энэ нөхцөл байдал чинь маш их тийм өөр болж байна. Тэгээд энэ бүхэнтэй чинь яаж уялдаж байгаа юм бэ гэдэг ийм л зүйлийг бид ярьж байгаа.

Г.Тэмүүлэн: Б.Жаргалан гишүүний асуултад хоёр сайд нэмж хариулт өгье. Л.Гантөмөр сайд, Ж.Энхбаяр сайд.

Л.Гантөмөр: Ер нь дэлхий ертөнц тогтворгүй болж байгаа.

Дэлхийн худалдааны дайн дараа дараагийнхаа дайны эхлэлийг тавьж байгаа. Тэгээд энэ худалдааны дайн тогтворгүй үед Монголчууд бид тогтвортой байх хэрэгтэй.

Дэлхий ертөнц ойлгомжгүй болж байгаа. Харин эсрэгээрээ Монголчууд бид ойлгомжтой байх хэрэгтэй.

Бид нарын ойлгомжтой байдал юу вэ гэвэл дотоодын үйлдвэрлэлийг босгож ирнэ. Үйлдвэрлэсэн бараагаа гадагшаагаа экспортолно. Гаднын хөрөнгө оруулалтыг татдаг тэр орчныг бүрдүүлнэ. Орж ирсэн хөрөнгө оруулалтыг нь хамгаална, дэмжинэ.

Бид хоёр хөрштэйгөө нягт хамтын ажиллагаатай байна. Сайн хөршийн харилцааг баримтална. Гуравдагч хөршдөө бид аль болохоор эдийн засгийн харилцаагаа нэмэгдүүлнэ.

Бид аягүй энгийн ойлгомжтойгоор л алхана. Тэр хүрээндээ бидний хийж чаддаг. Одоо жишээлбэл цагаан будаа бид Оросын Холбооны Улс руу заръя гээгүй шүү дээ. Машин хийгээд заръя гээгүй. Трактор заръя гээгүй.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Л.Гантөмөр сайд нэмээд. Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Махан дээр манай мах боловсруулах үйлдвэрүүд өнгөрсөн 2 жил үндсэндээ маш завгүй ажилласан.

Ер нь намартаа мал таргалахаар нэг жоохон мах бэлтгээд л зогсдог байсан. Одоо бол байнга ажиллаж байна. Үүнийг л урамшуулах хэрэгтэй. Одоо энэ дээр бид мал бэлтгэл дээр нь тэжээл, тэжээлийн үйлдвэрүүдийг дэмжиж байна. Тэжээл тариалалтыг дэмжиж байна. Ингээд бид өвлийн сэрүүн мал жингээ алдаж турдаг үед эсрэгээр нь малаа тэжээдэг, малаа таргалуулдаг, ингээд экспортод гаргадаг маягаар энэ аж ахуйгаа жаахан өөрчлөөд явахад экспортын бололцоо өндөр байгаа.

Сая бид 80 мянган тонн мах гаргалаа. Энэ нь ястай маханд шилжүүлэхэд 100-аас 120 мянган тонн болж байгаа юм. Энэ нь хонин толгой, богд шилжүүлэхэд нэг нь одоо 20 килограммын гулуузаар бодоход 5 сая толгой богийг бид экспортолчихсон байгаа юм. Үүнийг бид 10 хүртэл экспортлох бодитой дотоодын нөөц боломж байна.

Г.Тэмүүлэн: Б.Жаргалан гишүүн нэмж тодруулах уу? Б.Жаргалан гишүүн болсон уу? Г.Хосбаяр гишүүн.

Г.Хосбаяр: Би хувийн хэвшилд ажиллаж, бизнес хийж байсан хүн л дээ.

Тэгээд ер нь хувийн хэвшилд баялаг бүтээж, юм хийж бүтээчхээд тэрийгээ зарна гэдэг бол одоо бас нэлээн л хэцүү, ер нь нэлээн ухаан зарсан, бас төр засгийн бодлого, шийдвэр, дэмжлэг хэрэгтэй ийм ажил байдаг л даа.

Дотоодын зах зээл бол ханасан. Аль ч бизнесийн салбарт. Нэг хэсэг орон сууцын зах зээл жоохон ахиу эрэлттэй байсан. Том том компаниуд, үйлдвэр, үйл үйлчилгээтэй хүмүүс бүгд орон сууц руу давхиж ороод одоо энэ салбар ингээд ханачихсан. Бүх бизнесийн салбарууд ханачихсан л байна л даа.

Тэгэхээр тэр утгаараа энэ гадаад зах зээлд, том зах зээлд гарах ийм үүд хаалга нээгдэж байгаад том агуулгаараа дэмжиж байгаа юм.

Мэдээж үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах, хувийн хэвслээ хамгаалах ийм зүйлүүд байх байх. Тэгээд асуух асуулт бол энэ хэлэлцээр хийгдсэнээр тухайн улсуудаас гадаадын хөрөнгө оруулалт хэр орж ирэх вэ? Тийм тооцоо, судалгаа байгаа юу?

Ер нь өнөөдрийн бизнесийн зарчим дэлхий нийтээрээ хамтарсан үйлдвэр, одоо тэр бүтээгдэхүүнээ гаргах гэж байгаа улстайгаа бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа улс нь хамтарсан үйлдвэр юм байгуулж, хувь эзэмшиж байж л бас энэ бизнесийн загварууд чинь амжилттай явж байгаа шүү дээ. Тэгэхгүй бид эндээ

нэг баахан үйлдвэр байгуулчхаад л, бид нарын эцсийн бүтээгдэхүүнийг заавал та нар ав, бид ингэлээ, тэглээ гэдэг бол бас нэг талдаа өрөөсгөлөө.

Тийм учраас ер нь энэ гэрээ, хэлцэл магадгүй хийгдсэн тохиолдолд энэ хамтарсан үйлдвэрүүд, гадаадын хөрөнгө оруулалт хэр орж ирэх юм бэ?

Дээр нь түрүүн Э.Бат-Амгалан гишүүн ярьж байна. Энэ стандартын тухай асуудал байгаа. Монгол Улс бол өнөөдөр стандартын хувьд маш хоцрогдсон, стандартуудаа шинэчлэх шаардлагатай, шинэ гадна дотнын евро стандарт ч юм уу Монголд оруулж ирэх, нутагшуулах ийм зайлшгүй шаардлагууд бол тулгарчихсан байгаа.

Тэгэхээр зэрэг бид нарын энэ гаргах бүтээгдэхүүн маань яг одоо бидний зориод байгаа зах зээл маань “Евро стандарт” нэлээн нэвтрүүлсэн, “Евро стандарт”-тай зах зээл гэж ойлгож байгаа. Энэ зах зээл дээр шаардлага юмаа хангах уу?

Хоёрдугаарт нь, одоо “үйлдвэрлэлийн кластер” гэж ярьж байгаа. Энэ хагас боловсруулсан ч юм уу, одоо ингээд кластер байдлаар хөгжүүлж бүтээгдэхүүнээ илүү үнэ цэнтэй болгох тал дээр ер нь ямар бодлоготой байгаа вэ?

Мөн удахгүй Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль оруулж ирэх юм байна. Энэ хууль дээрээ энэ хэлэлцээр байгуулагдсан нөхцөлд гадаадын хөрөнгө оруулагчдыг, төр, хувийн хэвшлийг шинэ үйлдвэр, үйлчилгээг ингэж дэмжинэ гэсэн ийм зүйл, заалт юм байгаа юу? 1 минут нэмээд авч болох уу дарга.

Хоёр дахь асуулт нь, Ж.Энхбаяр сайдаас асуух гээд байгаа юм. Одоо өнөөдөр Монголын энэ хөдөөд тулгамдсан асуудал ноолуурын асуудал болчиход байна л даа.

Би өөрөө Өвөрхангай аймгийн Богд суманд төрж өссөн хүүхэд. Манай сум бол Монголын хамгийн олон ямаатай сум. Жилд 80 орчим тонн ноолуур гардаг. Тэр суманд чинь жилд 10 гаруй тэрбум төгрөг яг өдийд очоод л нэлээн эргэлт болоод л хүмүүсийн амьдрал ахуй, тэр нийгэм, орчин шал өөр болоод л явчихдаг ийм үе л дээ.

Гэтэл одоо өнөөдөр яг ирж байгаа мэдээллээр тэнд ямар ч ноолуур авахгүй байна. Нэг үнэ яриад яваад байна. Тэгэхдээ авахгүй байна гээд байна.

Тэгэхээр энэ дээр та бас нэг хэрэгжүүлж байгаа бодлого, шийдвэрээ хэлээч ээ. Би танаас сонссон. Дэмжиж байгаа. Гэхдээ яг өнөөдөр бодит байдал дээр ноолуур авахгүй байна. Энэ дээр ер нь яг ямар үг хэлэх вэ? Та. Энэ талаар нэг тайлбар хэлээч.

Г.Тэмүүлэн: Л.Гантөмөр сайд эхлээд хариулъя. Дараа нь Ж.Энхбаяр сайд нэмж тайлбар хариулт өгье.

Л.Гантөмөр: Тийм. Тэгэхээр Г.Хосбаяр гишүүний асуултад хариулъя.

Гаднын хөрөнгө оруулалт одоо энэ өндөр та тарифын үл ойлголцлын энэ цаг үед бол манайх руу ирэх бололцоо байна. Мөнгө их үнэтэй байна.

Тэгэхээр бид яах ёстой вэ гэхээр түрүүн Х.Тэмүүжин гишүүн хэлж байсан. Тэр орчноо зөв болгоод өгөөч ээ гэдэг асуудал байгаа. Тэгээд энэ дээр Засгийн газар яг төлөвлөсөн ажлуудаа цаг хугацаанд нь хийж чадах юм бол бид гаднын хөрөнгө оруулалт орж ирэх, орж ирээд энд үйлдвэрлэл эрхлэх, эрхэлсэн бараагаа танил зах зээл рүүгээ худалдах гэдэг энэ циклийг бид хийх бололцоо нэгдүгээрт байгаа.

Тэгэхээр Засгийн газар хэр сайн ажиллах вэ гэдгээс их юм хамаарна. Шулуухан хэлэхэд.

Хоёрдугаарт, бэлтгэн нийлүүлэлтийн сайн сүлжээ хэрэгтэй. Платформ нь алдаатай байна, ажиллахгүй байна, дутуу байна.

Тийм учраас манай Хүнс, хөдөө аж ахуйн яам санаачилгаа аваад, тэгээд Зам, тээвэр болоод бусад бид бүхэн тал талаас нь тусалж дэмжээд үндэсний хэмжээний ханган нийлүүлэх тогтолцоо руу анхаарах хэрэгтэй.

Тэр нь төр өөрөө хийе гэсэн үг ерөөсөө биш. Тэр ажил хийдэг ложистик, тэр тээврийн асуудал хийдэг. Хуучин бол ченж гэж нэрлэгдэж байсан улсуудын энэ орон зай маш их хумигдсан байна. Энэ орон зайн дээр хөрөнгө оруулж байгаа хөрөнгө оруулалтыг бид түлхүү дэмжье гэж байгаа.

Харилцан хөрөнгө оруулалтаар туслалцъя, хамтаръя гэж байгаа. Ингээд дараагийн шатны үйлдвэрлэл дээр ч ялгаа байхгүй бид хөрөнгө оруулалт хийгээд явах ёстой.

Ингэж байж нэгдсэн нийлүүлэлтийн тогтолцоо бий болох юм бол зөвхөн махаар тогтохгүй бид сүү болоод дайвар бүтээгдэхүүн, дээр нь ноос, ноолуур, арьс, шир, ялангуяа энэ хаягдаад байгаа бараануудаа бид жоохон ч гэсэн үнэлгээтэй болгож чадвал хөдөөд амьдрал сэргэнэ.

Тэр 450 мянган хүний амьдрал сэргэхээр аандаа Монголын эдийн засаг арай өөр болно гэдэг ийм л ойлголт байгаа учраас бид энэ гэрээ цаг үеэ олсон байна. Өнөөдөр хийж амжихгүй бол магадгүй ирээдүйд хийхэд их төвөгтэй болж эхлэх тийм нюанстай цаг үе байна шүү гэдгийг би гишүүддээ ойлгуулахыг уг нь хичээгээд л байгаа юм.

Бид их олон зүйлээс айж бэрхшээж, их олон юмыг хойшлуулж байсан. Хойшлох тусмаа үнэтэй болдог эд юм билээ л дээ. Эгийн голыг цагтаа хийсэн бол бид ямар их хожил авах байсан. Тавантолгойг цагт нь хийсэн бол бид ямар их хожил авах байсан. Төмөр замаа цаг хугацаанд нь тавьсан бол бид ямар урагшаа явах байсан. Аягүй олон болгоомжлол, маш олон ухаантай санаанууд гараад л асуудлыг хойш нь тавьдаг. Хойш нь тавьснаар ерөөсөө асуудал шийдэгддэггүй, улам хүнд болдог. Нөхцөл нь улам хүнд болдог ийм л зүйл байдаг юм билээ.

Тэгэхээр өнөөдөр гишүүд минь одоо бид нарын энэ оруулж байгаа хэлэлцээрийг дэмжиж, Монгол төрийнхөө үйл хэрэгт дэм болоорой гэж та бүхнээсээ чин сэтгэлээсээ хүсэж байгаа шүү. Баярлалаа.

Ноолууран дээр Ж.Энхбаяр сайд хариулаад. Тийм.

Г.Тэмүүлэн: Г.Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Товчхон мэдээлэл өгье. Ноолуурын үнэ.

- 2019 онд улсын дундаж 83 мянга 100,
- 2020 онд 51 мянга 940,
- 2021 онд 99 мянга 575,
- 2022 онд 105 мянга 797,
- 2023 онд 111 мянга 588,
- 2024 онд 123 мянга 927

гэсэн дундажтайгаар ноолуур худалдан авалт явагджээ. Үүн дотроос зүүн бүс хамгийн өндөр үнэ үзүүлж байсан.

Ингээд ноолуур маань өөрөө бүс нутаг, малын үүлдэр угсаа, өвөлжилтийн байдал, тэр юмтай хамаараад ингээд жил жилдээ өөр шүү дээ.

Тэгэхээр зүүн тал микрон нарийн, илүү үнэ авдаг. Тэгээд үндсэндээ зүүн талаас баруун тийш тусам ноолуурын чанарын бүтцийн нэлээд том өөрчлөлт, цаг уурын өөрчлөлттэй холбоотой гарч эхэлдэг. Ингээд нэг 20-иос 40 мянган төгрөгийн уналт хийж ирдэг.

Энэ жил зүүн 3 аймгийн ноолуур үндсэндээ 155-аас 168 мянган төгрөгөөр авагдаад дууссан. Одоо наашлаад төвийн бүсүүд, дундын бүс рүү орж ирж байна. Булган, Хөвсгөл аймгийн ноолуурууд идэвхтэй арилжаалагдаж байна. 130-аас 140 мянган төгрөгийн хооронд явагдаж байна.

Говийн сумуудад 100-аас Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, урд талд гээд 105-аас 135 мянган хооронд үнэ тогтож, тухайн үеийн өөрийн чанар, өвөлжилттэй холбоотойгоор ийм үнүүд явагдаж байна.

Бид “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд ноолуурынхаа үйлдвэрүүдэд 230.0 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийг шийдсэн.

Мөн сая дотооддоо жоохон зохион байгуулаад дахин 100.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: 1 минут нэмж өгье. Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: “Цагаан алт” хөтөлбөрийнхөө хүрээнд дахин 100.0 тэрбумын эх үүсвэр шийдэгдэж байна. Ингээд 330.0 тэрбум төгрөгөөр ноолуур худалдан авах байдалд аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлсэн.

Ингээд нөгөө талаас урд хөрш маань тарифын худалдааны дайнд орсонтой холбоотойгоор Монгол Улсад ирж ноолуур авдаг байдал идэвхжилт туйлын сул байгаа.

Иймд бид Засгийн газраас ноолуур авалт дээр дэмжлэг үзүүлэх үүднээс сая өнөөдрийн Засгийн газрын хурлаар Монголбанкнаас өрийн бичиг гаргаж үйлдвэрүүддээ ноолуур авах эх үүсвэрийг нь шийдэх 500 тэрбум төгрөгийн өрийн бичиг гаргах энэ асуудлыг үндсэндээ дэмжээд Монголбанк руу зөвлөмж хүргэж байна.

Монголбанк хэрхэн шийдвэрлэх тийм ерөнхий бүтэц, схемээ танилцуулсан.

Ингээд ямар ч байсан энэ жилдээ бид “Цагаан алт” хөтөлбөр хэрэгжүүлж байгаагийнхаа үр дүнд бид дотоодынхоо ноолуурын 70-аас 80 хувийг үндэсний үйлдвэрүүд авах санхүүгийн бололцоо бүрдэж байгаа гэдгээ хэлье.

Г.Тэмүүлэн: Г.Хосбаяр гишүүн болсон уу? Нэмж тодруулах уу? Нэмж тодруулъя.

Г.Хосбаяр: Тэр хагас боловсруулсан бүтээгдэхүүн гарах юм болов уу? Эсвэл одоо яг эцсийн бүтээгдэхүүн гарах юм уу? Эцсийн бүтээгдэхүүн гэхээр л стандарт, чанар, сав, баглаа, боодлоос өгсүүлээд л олон асуудал үүснэ дээ.

Тэгэхээр хагас боловсруулаад, эсвэл хамтраад, эндээ хагас боловсруулаад, тэндээ яг тухайн орондоо очоод эцсийн бүтээгдэхүүн болоод ингээд явах ч гэдэг юм уу ийм ер нь хувилбар, судалгаа юмнууд байдаг юм болов уу?

Г.Тэмүүлэн: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Хөдөө аж ахуйн гаралтай сүү, цагаан идээ, малын гаралтай өлөн гэдэс, яс, адууны дэл, сүүл, малын өөх, өөхөн тос гээд. Ингээд л чацаргана, арвай, будаа гээд. Олон төрлийн. Энд гэхэд 65 төрлийн бараа байгаа.

- ▶ Мах, махан бүтээгдэхүүн 29 байгаа.
- ▶ Арьс, ширэн бүтээгдэхүүн 60 байгаа.
- ▶ Ноос, ноолууран бүтээгдэхүүн 204 байгаа.
- ▶ Бусад дайвар бүтээгдэхүүний боловсруулалттай 65 байна.
- ▶ Мөн хайлуур жонш, давс, зэс, молибден, тугалга, гянт, болд гээд бусад уул уурхайн гаралтай бараа 9 байгаа.

Бид хийж л чадвал зах зээлээ ерөнхийдөө орон зайг нь нэлээн том онгойлгоод авсан.

Тэгэхээр бид өөрсдөө жоохон өөрчлөгдөх ёстой. Бахь байдагтаа байж болохгүй. Бид сав баглаагаа янзална, стандартаа янзална, технологио янзална, чанар аюулгүй байдал баталгаагаа янзална.

Ингээд үүний үр дүнд манай аж ахуйн нэгжүүд шинэ түвшинд гарах буюу том зах зээлд гарах.

Хамгийн гол нь энэ хүйтэн бүсийн зах зээл гэдэг л их давуу талтай. Манай уламжлалт зах зээл байхгүй юу. Олон жил манай мал мах, ноос ноолуур, арьс ширэн эдлэлийг хэрэглээд дассан их том үе байгаа.

Тэгээд эндээ дахин үүнийгээ сэргээх талаасаа боломж нэлээн гарна гэж.

Г.Тэмүүлэн: Г.Хосбаяр гишүүн болсон уу? Тийм ээ. Гишүүд асуулт асууж дуусаж байна. Бусад гишүүдийг дуудаарай.

Тодорхой ганц хоёр асуултуудыг нэмж би хувь хүнийхээ үүднээс асууя гэж бодож байна.

Мэдээж энэ өөрөө Монгол Улсын нийгэм, эдийн засагт нөлөө үзүүлэх худалдааны том хэлэлцээр, чөлөөт худалдааны хэлэлцээр. Тэгээд үүнтэй холбоотойгоор гишүүдийн хэлж байгаа асуудал “харилцан ашигтай байх” гэдэг асуудал хөндөж яриад байгаа юм. Харилцан ашигтай байх.

Тэгэхээр бид бүхний хувьд экспортод гаргах бүтээгдэхүүний маань боломж бололцоо бий болно гээд Та бүхэн тооцоо судалгаа үзүүлээд байгаа. Экспорт 24.2 хувиар өснө. Энэ дотроо 367 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн

буюу 97.5 хувь нь хөдөө аж ахуй буюу мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн байна гэдэг асуудлыг тавиад байгаа.

Энэ хэрэв яг тооцоо, судалгаа зөв бол, эрсдэлийн үнэлгээгээ бид зөв хийсэн бол магадгүй энэ хэлэлцээр харилцан ашигтай байх, Монголын тал хөдөө аж ахуйн салбартаа хэрэгтэй зүйл болох болов уу гэж хараад байгаа юм.

Тэгэхээр энэ дотор ноос, ноолууран эдлэл, мах, арьс шир гээд. Энэ нь өөрөө 204 нэр төрөл, 60 нэр төрөл, мал, махан бүтээгдэхүүн дээр 29 нэр төрөл, хөдөө аж ахуйн бусад бараа 65 нэр төрөл гээд бараг үндсэндээ 300 орчим нэр төрлийнх нь бараа, бүтээгдэхүүн хөдөө аж ахуйн салбартай холбоотой асуудал байна л даа.

Тэгэхээр энэ дээр гишүүд асуугаад байгаа юм. Э.Бат-Амгалан гишүүн ч асуулаа, Г.Хосбаяр гишүүн ч асууж байна.

Үндсэндээ энэ тарифын бус хориг саадыг багасгахтай холбоотойгоор, худалдааг хөнгөвчлөхтэй холбоотойгоор яг Монголын тал өөрөө гэрийн даалгавраа хийж байгаа юм уу? Бэлтгэл ажлуудаа хийж байгаа юм уу? Одоо бид нэг талдаа хэлэлцээр хийлээ гэвэл нөгөө “саалиа бэлдэхээр саваа бэлд” гэдэг шиг бид чинь өөрсдөө саяын энэ мал, махан бүтээгдэхүүнтэй, арьс ширтэй холбоотой, хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүнтэй холбоотойгоор гарал үүсэл, баталгаажуулалтын асуудлаар яг ямар ажлыг энэ жил хийх гэж байгаа юм, ирэх жил ямар ажлыг хийх гэж байгаа юм. Тухайн бүтээгдэхүүнийхээ мөшгөх тогтолцоог сайжруулах тал дээр бид ямар ажил хийх гэж байгаа юм, бүртгэл чанарын баталгаажуулалтын асуудлаар ямар ажлыг хийх гэж байгаа юм гэдэг асуудал.

Үндсэндээ манай гаргаж байгаа бараа, бүтээгдэхүүн маань өөрөө гарал үүсэл, эрүүл мэнд болоод чанарын хувьд баталгаатай байх. Нөгөө хүн гадагшаа явахад ногоон паспорттой байх, паспорттой байх гэдэг асуудал яригддаг шиг тухайн тэр мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн дээр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн дээр дагалдаж гарах тэр стандарт чанар, шаардлагын асуудлыг бид өөрсдөө яаж биелүүлэх гэж байгаа юм бэ гэдэг асуудал байгаа.

Тэгэхээр үүнийг гишүүд энэ жил, ирэх жил яаж хийх юм. Бид өөрсдөө гэрийн даалгавраа, ажлаа сайн хийснийхээ үндсэн дээр үүнийг яаж экспортыг нэмэгдүүлэх юм бэ гэдэг тодорхой асуултыг асуугаад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр яг ямар асуудал байна? Магадгүй махны үйлдвэрүүд зүгээр мал, махаа л авна шүү дээ. Тэр бэлчээрт байгаа малыг яаж бид чанарыг нь баталгаажуулах юм, гарал үүслийг нь баталгаажуулах юм, мөшгөх тогтолцоог нь яаж баталгаажуулах юм гэдэг асуудал чинь өөр болчихоод байгаа юм. Тэр байхгүй бол үндсэндээ ямар ч бараа, бүтээгдэхүүн гарахад хүндрэлтэй л байна.

Өнөөдрийн бид нарын магадгүй 10, 20 жилийн таг гацсан, зогссон асуудал ерөөсөө л эндээ л байгаа юм.

Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилт өөрөө хангалт муутай байдаг. Тэгэхээр та хэд маань энэ дээр анхаарч ажиллах нь зүйтэй болов уу л гэсэн энэ асуудлыг би хөндөж хэлэх гээд байгаа юм.

Хоёр дахь асуудал нь, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга орж ирнэ гэж нэрээ өгсөн боловч Сангийн яамнаас ямар нэг төлөөлөл энд байхгүй байна.

Энэ хэлэлцээртэй холбоотойгоор гаалийн татвар болоод албан татвар, НӨАТ, онцгой албан татварууд дээр ямар төсөөлөл, тооцоололтой байгаа юм бол? Одоо би тэгээд Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуухад хариулт өгч чадах уу, үгүй юу? Үндсэндээ уг нь Сангийн яамныхан орж ирээд л хариултаа өгмөөр байх юм. Байхгүй бол Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрын дарга нар нь орж ир гээд өгмөөр байх юм.

Нөлөөллүүд үүсэх юм уу? Мэдээж яах вэ, гааль дээр шууд нөлөө үүснэ. Хэд хэдэн тэрбум төгрөг үүсэх юм.

Эргээд тодорхой хэмжээний архи, тамхи, пивотой холбоотой асуудлууд 25 хувиар хөнгөлөгдөх ч гэдэг юм уу, чөлөөлөгдөх асуудлууд орж ирж байгаа.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор дотоодын аж ахуйн нэгж үйлдвэрүүдээс авах онцгой албан татвар, бусад НӨАТ, албан татварууд дээр жишээ нь нөлөөлөл үзүүлэх юм уу, үзүүлэхгүй юм уу, төсөвт ямар нөлөөлөл гарах юм, тоо хэмжээ хэр буух юм гэдэг асуудлуудыг уг нь асуумаар байгаа юм.

Одоо тэгээд байхгүй хүмүүсээс одоо яамаар юм. Эсвэл хариуцлагаас зугтаад яваад байгаа юм уу. Засгийн газар дээрээ Сангийн яамны энэ асуудлууд дээр ямар байр суурьтай байсан юм бэ гэдэг ийм л хоёр үндсэн асуудлыг л асуух гэсэн юм.

Л.Гантөмөр сайд.

Л.Гантөмөр: Тийм. Мэдээж хэрэг өнөөдөр бид 3 тэрбум долларын бараа, бүтээгдэхүүн импортолж байгаа. Үүний 90 хэдэн хувь нь туслах материал байгаа. Тийм ээ. Бензин, дизель түлш гэх мэтчилэн. Энэ бараа, бүтээгдэхүүнүүд дээрх гаалийн татварыг хөнгөлнө. Чөлөөлөгдөх юм. 5 хувь.

Тэгэхээр үүнтэй тэнцэх хэмжээний татварын орлого буурна. Нөгөө талдаа үнэ хямдарна гэсэн ийм л зүйл харж байгаа. 300 тэрбум төгрөг орчим гэж та ойлгож болно.

Г.Тэмүүлэн: Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Та их чухал асуудал хөндлөө. Зах зээл нээгээд өглөө. Бид бэлэн байна уу. Бэлэн зүйл ч байна, дутуу зүйл ч байна.

Энэ жилийн төсөв, санхүүгийн бодлого бол хувийн хэвшилдээ хөрөнгө оруулалт буюу үйлдвэрлэлийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэчлэхэд зориулаад нэлээн эх үүсвэр, эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийг нь гаргаад өгчхөж байгаа юм.

2026 оны бодлогод бид мал эмнэлгийн тогтолцоог шинэчлэх, лабораториудыг шинэчлэх, таны энэ хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд гэдэг бол мөшгөх тогтолцоо их нарийн байдаг. Чанар, аюулгүй байдал, хорио цээрийн асуудал олон улсын их айхтар том хяналтад байдаг. Үүнийгээ бид сайжруулах том ажил хийнэ.

Нөгөө талаасаа малынхаа үржил селекцийг сайжруулах, ялангуяа үхэр сүрэгт бид онцгой анхаарна. Тэжээлийн таримлуудыг эрс нэмэгдүүлнэ. “Атар-IV” аяны хүрээнд 200 мянган га талбайгаар талбай нэмж байгаа. Энэ хүрээнд тэжээлийн массыг нэмж байж бид мах бэлтгэл дээр нэлээн анхаарна.

Ингээд хүний нөөцийг бэлтгэх, манай салбарын тогтолцоог зөв болгох нэг.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Ж.Энхбаяр сайдад микрофон өгье.

Ж.Энхбаяр: Хүнс, хөдөө аж ахуйн салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байгаа.

Одоо яг бидний дэргэд байж энэ бодлогыг зөвлөж чиглүүлэх учиртай хөдөө аж ахуйн чиглэлийн 4 хүрээлэн байгаа. Энэ хүрээлэн өөр яаманд харьяалагдаж байгаа. Үүнийг яаралтай Хүнс, хөдөө аж ахуйн яамны дэргэд бий болгох хэрэгтэй байна.

Хүний нөөц бэлдэж байгаа, мэргэжилтэй боловсон хүчин бэлдэж байгаа тогтолцоогоо эрс өөрчлөх хэрэгтэй. Яг энэ зах зээлд чиглэсэн оловсон хүчнийг богино хугацаагаар бэлдэж, тэр үйлдвэрлэлд ажиллах хүчээр хангах томоохон зайлшгүй бодлого явуулах ёстой.

Лабораториудын чадавхыг олон улсын түвшинд нэмэгдүүлэх ёстой. Бид сая Биокомбинатад 2 шугам, арьс ширний олон улсын магадлан итгэмжлэгдсэн сая шинэ лабораторийг дөнгөж ашиглалтад оруулаад дуусаж байна. Ноос, ноолуурынх бол харьцангуй их өндөр түвшинд байдаг.

Ингээд хилийн бүсүүд дэх, хойд чиглэлийн худалдаанд хийх тэр боомтуудын хөгжлийн асуудлыг түргэтгэх, дэд бүтцийг нь хурдан холбох, тэнд хорио цээрийн, мал эмнэлгийн, малын экспорт, импортын тэр байгууламжуудыг яаралтай барьж дуусгах гэсэн мэтийн энэ төслүүдийг 2026 оны бодлогодоо төсвийн хүрээнд тусгаж оруулж ирнэ.

Энэ дээр дэмжлэг үзүүлж ажиллахыг гишүүдээсээ хүсье.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Х.Тэмүүжин гишүүнээр тасалъя. О.Амгаланбаатар гишүүн үг хэлнэ.

О.Амгаланбаатар: Гэрээ болоод их сайхан болох юм байна гэж ойлгогдохоор л ярьж байна.

Тэгээд гэрээгээ байгуулсны дараа саяын, ялангуяа энэ ажил хариуцсан улсууд нь, сайд нар нь тэгээд ажлаа яг саяын ярьсан шигээ сайхан байх болтугай л гэж хэлье дээ. Тэгээд 3 жилийн дараа гэдэг чинь 3 жилийн дараа сайхан сонгууль болно.

Тэгээд та хэдийн маань яриад байгаа зүйл сайхан биелчихсэн байх юм бол Монголын хөдөө аж ахуй өөр болоод, экспорт сайжраад энэ Б.Пүрэвдоржийн лоббиг хийгээд байгаа мах нь их сайн гарах юм байна л гэж ойлгож байна шүү дээ.

Тэгэхээр энэ нь одоо тэгээд цаг хугацаа шүүгээд өгнө дөө. Тэгээд та хэд маань энэ ажлаа сайн хийгээрэй л гэж хэлье.

Г.Тэмүүлэн: Х.Тэмүүжин гишүүн үг хэлнэ.

Х.Тэмүүжин: Яг энэ гэрээтэй холбоотой л дахиад хэлье.

Түрүүн хэллээ. Төөрөгдсөн мэдээлэл, буруу мэдээлэл өгчих шиг боллоо гээд. Би чинь Ж.Энхбаяр гишүүнийг телевизээр гадагшаагаа мах гаргахыг хорилоо гэж хэлэхийг хоёр цийлгэрээр хараад суусан хүн шүү дээ.

Тэгээд Засгийн газар, эрхэлсэн сайд нь өөрөө шийдвэр яаж гарсан нь тусдаа, олон нийтэд зарлахаараа өөр юм яриад. Тэр нь худлаа байсан байдаг гэдэг ийм арга барилаар ажилладаг л байгаад байх юм бол хөрөнгө оруулалт угаасаа орж ирэхгүй. Хувийн бизнес эрхлэгчид чинь төөрөлдсөн байдалд байнга орно. Дээр нь энэ үл ойлголцсон байдал чинь дахиад л өрсөлдөөнд дандаа сул тал болж хувирна.

Тэгэхээр зах зээлийг нээж байна, өөр өрсөлдөгчийг оруулж ирж байна гэж л байгаа л бол Засгийн газар ядаж л үнэн хэлэх, зарчимтай байх, гаргасан шийдвэр дээрээ тодорхой үндэслэлтэй зогсох гэх мэтчилэн ийм алхмуудаа хийхгүй бол энэ ярьж байгаа гоё зүйлүүд чинь 3 жилийн дараа уруугаа хараад зогсож байж магадгүй шүү. Би ийм л үг хэлэх гэж байгаа юм.

Ер нь их болгоомж бий. Маш их сэргэмжилсэн өнгө аястай олон нийт харж байгаа. Энэ сэрэмжлэсэн, болгоомжилсон зүйлийг бодит байдал болгоод 3 жилийн дараа уулзахгүйн тулд Засгийн газар түрүүний хэлсэн бизнесийн орчноо сайжруул, хууль тогтоомжоо ойлгомжтой болго, энэ төрийн дарамтаа зогсоо. Дээр нь хөрөнгө оруулалтын боломжийг боломжоор нь нээ.

Энэ алхмаа хийхгүй бол энэ сөрөг болно шүү. Засгийн газарт бараг өнөөдөр зогсож байгаагаас чинь илүү дахиад 200 дахин хувь ажил бий болж эхэлж байгаа л гэсэн үг. Би энэ үгийг л хэлэх гэж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Гишүүд үг хэлж дууслаа.

Тэгээд худалдааны түр хэлэлцээртэй холбогдуулаад Засгийн газрын зүгээс ажил хариуцсан сайд нар маань хариуцлагатай ажиллаарай. Хариуцлагатай ажиллаарай.

Тэр дундаа төрийн эрх барих дээд байгууллага болсон Улсын Их Хурал гишүүдийн хэлсэн саналаар сайжруулах чиглэлээр ажиллаарай гэдэг би зарчмын асуудлыг хөндөж Та бүхэндээ хэлэх гэж байгаа юм.

Тэгээд үндсэндээ Монгол Улс парламентын засаглалтай улс орон. Төрийн эрх барих дээд байгууллагынх нь төлөөлөл нь болсон гишүүд тодорхой асуудлууд дээр байр сууриа хэлж байна.

Үндсэндээ хөдөө аж ахуйн салбар болоод хүнсний хангамж, дотоодын үйлдвэрлэлээ хэрхэн хамгаалах вэ гэдэг асуудлууд дээр л бүгдээрээ санаа зовниж хэлж байгаа асуудал.

Тэгэхээр үүн дээр Та бүхэн маань тэр нэр төрөл бараа, бүтээгдэхүүн оруулж ирэх импортын асуудлууд дээрээ тодорхой хэмжээнд бууруулах, дотоодынхоо үйлдвэрлэлийг хамгаалах чиглэлүүдээр, магадгүй тэр сүү, сүүн бүтээгдэхүүн, тамхитай холбоотой асуудлууд гэдэг юм уу нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийг хамгаалах асуудлууд дээр анхаарал хандуулж, гишүүдийн ажил хэрэгч байдлаар санал тавьсан саналуудыг анхаарч үзэх ёстой гэж харж байгаа шүү.

Дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудын хөдөлмөрийг үнэгүйдүүлэх асуудал зарчмын хувьд байж болох ёсгүй. Ард нь бид харилцан ашигтайгаар

манай экспорт нэмэгдэж, эргээд бараа, бүтээгдэхүүн нэмэгдсэн байх, экспортын орлого нэмэгдсэн байх энэ асуудал гол суурь зарчмын асуудал гэж харж байгаа.

Тэгээд гишүүд бас шүүмжлэлтэй хандаж байгаа асуудлууд байгаа шүү. Та хэд анхаарч үзээрэй. Эрсдэлийн үнэлгээ байхгүй байна гэдэг асуудлуудыг яриад байна. Хийсэн юм уу, үгүй юм уу гэдэг асуудлууд байна. Хөндлөнгийн судалгаа хийсэн юм уу, бусад өөр улс орнуудын туршлага хэрэгжилтийг харсан юм уу? Яг харилцан ашигтай байх асуудлууд дээр буюу экспортод гаргах бүтээгдэхүүнийхээ боломж бололцоог нэмэгдүүлэх дээр анхаарч ажиллах ёстой гэж яриад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр манай сайд нар, Засгийн газар анхааралтай хандаж ажиллаж, илүү сайжруулах чиглэлээр ажиллаарай. Энэ бол зөвхөн зөвшилцөх асуудал. Эргээд Улсын Их Хурал дээр магадгүй хэрэв зөвшилцөх асуудал дэмжигдэх тохиолдолд Улсын Их Хурлаар орж ирж худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах, эцэслэн батлуулах асуудал орж ирнэ.

Тэгэхэд магадгүй гишүүд өмнөх хэлсэн асуудлууд, саналаараа ам асуух нөхцөл байдал үүснэ.

Саяын тэр тарифаас гадна, татвараас гадна бид бүхний хөндөөд байгаа асуудал бол үндсэндээ бид бүхэн өөр өөрсдийнхөө экспортын боломж бололцоог нэмэгдүүлэхийн тулд тарифын бус хориг саадыг багасгах тал дээр, худалдааг хөнгөлөх тал дээр бид ажиллах ёстой.

Бусад өөр нөгөө талтай ярилцах ёстой. Урьдчилж хэлэлцээрээ хийх ёстой. Бараа, бүтээгдэхүүнүүдээ энэ хориг саадыг багасгах тал дээр бид урьдчилж яриа хэлэлцээнүүдийг боломжит худалдан авагч нартай зах зээлтэй ярилцах ёстой байгаа.

Магадгүй бид нарт хүндрэл үүсэж магадгүй. Беларусын тэр үхрийн махтай бид яаж өрсөлдөх вэ гэдэг асуудлууд байна. Хониныхоо махыг нийлүүлэх боломж бололцоо байна уу, үгүй юу гэдэг асуудлууд байна. Өөрсдөө гэрийнхээ даалгаврыг сайн хийх, бэлтгэл ажлуудаа хангах асуудлууд байна.

Үндсэн үндсэндээ бид зөвхөн энэ Европ, Төв Азийн улс орнууд руу ч биш ер нь бусад бүх улс руу, урд хөрш рүүгээ ч гэсэн мах гаргая гэсэн. Үндсэндээ бид бүхний асуудал бол өөрсдийн дотоодын л асуудал байгаа юм. Өөрсдийнхөө гэрийн даалгаврыг хийдэггүй, ажлаа хийдэггүй, бэлтгэл ажлаа хангадаггүй, стандартад нийцүүлэх талаар хуулийг хэрэгжүүлэх талаар бид хөрөнгө мөнгө санхүүжилт болоод идэвх санаачилга гаргадаггүй асуудал бол байгаа шүү.

Мал, махны гарал үүсэл, баталгаажуулалт, мөшгих тогтолцоо, тухайн эрүүл ахуйн баталгаажуулалт, чанарын баталгаажуулалт болоод бүртгэлтэй холбоотой асуудлууд хамгийн хүндрэлтэй бид бүхний өөрсдийн том алдаа

байгаа. Бид өөрөө өөрсөд дээрээ дүгнэлт хийх зайлшгүй шаардлага байгаа гэж харж байгаа.

Тэгэхээр энэ дээр та нар маань анхаарч сайн ажиллаарай. Гишүүдийн хэлсэн санал бүрийг тэмдэглэж авч, эргээд Засгийн газар энэ дээр тайлбар хариу, нөгөө талдаа ярилцаж сайжруулах чиглэлээр ажиллах ёстой гэсэн саналыг би Байнгын хорооны даргын хувьд дүгнэж хэлэх байна.

Ингээд санал хураалтыг явуулна. Гишүүд үг хэлж дууссан. Санал хураалтыг явуулъя.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийг зөвшөөрч гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. /алх цохив/

Түр хэлэлцээрийн төслийг Байнгын хороонд оролцсон гишүүдийн олонх нь дэмжлээ.

Эсрэг төхөөрөмж гарсан гишүүд байна уу? С.Эрдэнэбүрэн гишүүн үү? С.Эрдэнэбүрэн гишүүн дэмжлээ.

Нийт санал хураалтад 19 гишүүн оролцсоноос 11 гишүүн дэмжсэн байна.

Ажлын хэсэг болоод Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. /алх цохив/

Хуралдаан 2 цаг 18 минут үргэлжилж, 16 цаг 05 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

ЦАЛТАН-ОД